



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН 2022 ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

"Тогтвортой хөгжлийн зорилго" өдөрлөгт
оролцсон бүжигчид ©НҮБ-ын СЗГ

2023 оны 3 дугаар сар

МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН
2022 ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН



Тогтвортой хөгжлийн зорилго өдөрлөлт оролцсон хүүхдүүд хөгжлийн талаар өөрсдийн дуу хоолойгоо өргөв. ©НҮБ-ын СЗГ

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	2
МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ	4
МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМ ДЭХ ГОЛ ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД	5
БҮЛЭГ 1: МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	6
Хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд	8
БҮЛЭГ 2: НҮБ-ЫН 2017-2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУДАД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ	10
2.1 НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээний (ХТХ) үр дүн	12
2.2 НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээний тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилт, гарц	14
Үр дүнгийн зорилт 1	14
Үр дүнгийн зорилт 2	22
Үр дүнгийн зорилт 3	30
2.3 "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн санхүүжилт, түншлэлийг дэмжих	36
2.4 НҮБ-ын хамтын ажиллагааны үр дүн: НҮБ-ын үйл ажиллагааны харилцан уялдаа, үр дүн, нөлөө	39
2.5 Үнэлгээ, ХТХ-г хэрэгжүүлэх хүрээнд олж авсан сургамж	42
2.6 Санхүүжилт, хөрөнгийн татан төвлөрүүлэлт	44
БҮЛЭГ 3: НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГААС 2023 ОНД ТӨВЛӨРЧ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛҮҮД	46
ХАВСРАЛТ:	49
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:	52

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын хувьд 2022 он олон сайхан онцлох үйл явдал тохиосон жил болж өнгөрлөө. Бид төлөвлөсөн үр дүндээ хүрч, олон шинэ боломжуудыг нээж Монгол Улсыг "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн зорилтуудаа хангахад нь стратегийн гол түнш байж, дэмжлэг үзүүлэн ажиллав.

НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ) 2017 оноос 2022 оны хооронд амжилттай хэрэгжин дуусч байгаатай холбогдуулан НҮБ-аас Монгол Улстай стратегийн түншлэлээ улам өргөжүүлж, ирэх 5 жилийн хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон баримт бичигт Монгол дахь

НҮБ болон Монгол Улсын Засгийн газар 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан билээ.

Түүнчлэн 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттереш Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь бидний хувьд хамгийн бахархалтай онцлох үе байв. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын энэхүү албан айлчлал нь Монгол Улсыг "Энх тайвны бэлгэ тэмдэг" болохын сацуу НҮБ-ын ажил үйлсэд чухал хувь нэмэр оруулагч, үнэ цэнэ бүхий гол хамтрагч улс орны нэг гэж онцлон тодотгосон юм.

Монгол дахь НҮБ өнгөрсөн онд тогтвортой хөгжлийн зорилгуудыг (ТХЗ-ууд) үндэсний тэргүүлэх чиглэл болгож, зорилгуудын биелэлтийг хангахыг тууштай дэмжлээ. НҮБ-ын зүгээс өнгөрсөн жилийн хугацаанд олон төрлийн арга хэмжээ, уулзалт ярилцлага, хэлэлцүүлэгийг зохион байгуулсан нь "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн хүрээнд өгсөн үүрэг амлалтын ач холбогдлыг дахин сануулж, ТХЗ-уудыг хангахад хувь хүний болон хамтын ажиллагааг идэвхжүүлэх, урам зориг өгөх гол түлхэц болов.

Монгол Улс дахь НҮБ Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран 2022 онд "Олон улсын цахим шилжилтийн яриа хэлэлцээ"-г анх удаа зохион байгуулж, дэлхийн цахим шилжилтийг тэргүүлэгч улс орнуудын дунд Монгол Улсын хүчин чармайлтыг тодотгож өгсөн билээ. Энэхүү олон улсын хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь Монгол Улсын хувьд цахим шилжилт хийж буй туршлагаа олон улстай хуваалцахаас гадна ижил төстэй бусад улс орнуудын туршлага, тулгарч буй сорилт, шийдлүүдээс суралцах, санал солилцох гүүр болж, ТХЗ-уудын хэрэгжилтийг хурдасгах нэг хэрэгсэл болсон юм.

Түүнчлэн, НҮБ-аас үндэсний хэмжээнд боловсролын салбарын бүх оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, "Хувьсан буй боловсрол" үндэсний чуулга уулзалтад амжилттай оролцоход дэмжлэг үзүүлсэн явдал байлаа. 2022 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы үеэр болсон "Хувьсан буй боловсрол" дээд хэмжээний чуулга уулзалт дээр Монгол Улсын боловсролын салбар дахь цахим шилжилтэд учирч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн санаачилгыг амжилттай танилцуулахад дэмжлэг үзүүлсэн нь хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг тууштай сурталчлах, чиглүүлэх үүрэг хүлээсэн миний хувьд нэр төрийн хэрэг болсон юм.

НҮБ эх дэлхийгээ аврах нэн чухал үйлст залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад шинэ санаачилга гаргаж буй хүчин чармайлтаа үргэлжлүүлэн, эерэг нөлөөллийн ажлыг хамтын хүчээр хийсээр байна.

Монгол дахь НҮБ-ын хувьд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо чадавхыг дэмжих нь тэргүүлэх асуудлын нэг байсаар ирсэн бөгөөд хэнийг ч хөгжлөөс орхигдуулахгүй байх зарчмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орхигдох эрсдэлтэй эмзэг бүлгийн иргэд зэрэг цөөнхийн бүлгийг оруулан хүний эрхийг дэмжих хүчин чармайлтаа эрчимжүүлсээр байна.

НҮБ-ын Хөгжлийн системийн шинэчлэлийг хөрсөн дээр буулгаж, үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хамтран томоохон хоёр хөтөлбөрийг зорилтот бүлгүүдэд чиглүүлэн амжилттай хэрэгжүүлээ.


Энэхүү тайлангаар дамжуулан ХТХ-г хэрэгжүүлсэн зургаан жилийн ололт амжилт, Монгол Улсын Засгийн газар болон бусад түнш байгууллагуудтай өрнүүлсэн амжилттай хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийнхээ үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна.

"КОВИД-19" цар тахлын хүнд цаг үед НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд Монгол Улсад вакцины хангамжид дэмжлэг үзүүлсэн нь цаг үеэ олсон чухал дэмжлэг байлаа. Энэхүү хүчин чармайлтын үр дүнд нийт зорилтот хүн амын 80 хувь вакцинжуулалтад хамрагдсан ба цар тахлын нийгэм-эдийн засгийн үр нөлөөнд чиглэсэн арга хэмжээг хамтын хүчин чармайлтаар авч хэрэгжүүлсэн билээ.

Иймд хэнийг ч ардаа орхихгүйгээр Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хурдасгах НҮБ-ын хүчин чармайлт, ажлын үр дүнд хувь нэмрээ оруулж ирсэн бүх оролцогч талуудад чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

Энэхүү тайлан та бүхэнд өнгөрсөн хугацаанд явуулсан үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнгийн талаар олж мэдэхэд тусална гэдэгт би итгэлтэй байна.

НҮБ-аас Монгол Улсад хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ" баримт бичиг 2023 оноос эхлэн хэрэгжиж эхлэх ба энэхүү баримт бичгийг амжилттай хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хамтран ажлын төлөвлөгөө боловсруулж, Монгол Улсыг ТХЗ-ууддаа хүрэхэд түлхэц болох, иргэдийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд, хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийн үр шимийг хүртэхэд хувь нэмрээ оруулан ажиллахаар байгааг дуулгахад таатай байна.



ТАПАН МИШРА

НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагч

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ



Талан Мишра
НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагч




ХХААБ
Винод Ахужа
НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч



ОУАЭА
Рафаэль Мариано Гросси
Олон улсын атомын эрчим хүчний агентлагийн Ерөнхий захирал



ОУХБ
Чанхи Ли
ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны захирал



ОУШХБ
Жьюзеппе Крочетти
ОУШХБ-ын БНХАУ болон Монгол Улс дахь салбарын тэргүүн



НҮБХХ
Илейн М. Конкиевич
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч



НҮБ-ын БОХ
Мүүн Шреста
НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн Хөтөлбөрийн мэргэжилтэн




АНДЭЗНК
Баасанжавын Ганболд
НҮБ-ын АНДЭЗНК-ын Зүүн, Зүүн-Хойд Азийн газрын захирал



БШУСБ
Шахбаз Хан
ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын захирал



НҮБ-ХАС
Халид Шарифи
НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улс дахь тэргүүн



НҮБ-Хабитат
Лаксман Перара
НҮБ-ын Хабитат байгууллагын Япон улс дахь салбарын Хүний суурьшлын асуудал хариуцсан мэргэжилтэн



НҮБ-ХС
Эваристе Коуасси-Комлан
НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч



АҮХБ
Стивен Б. Каргбо
НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагын БНХАУ, БНАСАУ болон Монгол Улсыг хавсран суугаа Суурин төлөөлөгч



ДЭМБ
Сергей Диордица
ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМИЙН ХӨГЖЛИЙН ГОЛ ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



Монгол Улсын Засгийн газар



Монгол Улсын Их Хурал



Даян дэлхийн байгаль орчны сан



БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг



Швейцарын хөгжлийн агентлаг



НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөр ба Олон талт түншүүдийн итгэлцлийн сан



Европын Комисс



НҮБ-ын ТХЗ хамтарсан сан



Уур амьсгалын ногоон сан



Австралийн олон улсын хөгжлийн агентлаг



АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг



Люксембургын Их Гүнт Улсын Засгийн Газар



Дэлхийн банк



Оюу толгой компани



ГАВИ вакцины эвсэл



БНСУ-ын Олон улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сан



Канад Улсын Засгийн газар



НҮБ-ын Хүүхдийн сангийн Канад дахь Үндэсний хороо



Япон Улсын Засгийн газар



НҮБ-ын КОВИД-19 ОТТИС



Дасан зохицлын сан

1 БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ТХЗ-ЫН ҮНЭЛГЭЭ

163 орноос
109-р байрт:¹
63.51



- Хотод **47%**
- Хөдөө **53%**
- 15-аас доош насны хүн ам **32%**
- 1000 хүн амд ногдох төрөлт **19.6**

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

4.8%
(2022)³



ИНФЛЯЦЫН ТҮВШИН

13.2%
(2022)⁴



ЯДУУРЛЫН ТҮВШИН

27.8%
(2020)⁵




ЖИНИ ИНДЕКС

34.0%
(2022)⁶



ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫН ИНДЕКС

0.313
191 орноос
76-р байрт (2021)⁷



ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

0.739
191 орноос
96-р байрт (2021)⁸



Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-уудын үнэлгээгээр 163 орноос 109-р байрт жагсаж, 63.5 оноо авсан нь Зүүн ба Өмнөд Азийн бүс нутгийн дунджаас⁹ 2.4 хувиар доогуур байгаа үзүүлэлт болжээ. Ази, Номхон далайн бүс нутгийн нийгэм-эдийн засгийн комисс (АНДБННЭЗК)-оос ТХЗ-уудын үндэсний үзүүлэлтүүдийн хүрээн дээр үндэслэж боловсруулсан ТХЗ-уудын явцын дүн шинжилгээгээр Монгол Улс 2015 оноос хойш нэгдүгээр зорилгын хүрээнд ухарсан байгаа бол харин бусад бүх зорилгын хувьд тодорхой хэмжээний ахицтай байгаа нь харагдсан байна. Тухайлбал, тус шинжилгээгээр 11, 13, 16, 17 дугаар зорилгуудын хувьд Монгол Улс 2022 онд хүрэхээр зорьсон түвшиндээ хүрсэн байна. “КОВИД-19” цар тахлаас улбаалан худалдааны гол түнш болсон Хятад улс хилээ хааж, импортын бараа, бүтээгдэхүүний эргэлт удааширсан нь дотоодын үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байв. Түүнчлэн, 2022 оны эхээр эхэлсэн ОХУ - Украйны дайн Монгол Улсын нийгэм эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн билээ. НҮБ-аас “КОВИД-19” цар тахал болон ОХУ - Украйны дайны Монгол Улсад үзүүлж буй нөлөөг нарийвчилж судалсан ба тус судалгаагаар гадаад орчны энэхүү тогтворгүй байдал нь өрхийн амьжиргаа, бизнесийн орчинд маш хүчтэй сөрөг нөлөө үзүүлэхээс гадна жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн шим, тэжээлийн асуудалд хүртэл сөргөөр нөлөөлж байгааг харуулсан байна. Цаашилбал, тус судалгаагаар гадаад орчны эдгээр сөрөг нөлөөлөл нь хөдөөгийн малчин иргэд, өрх толгойлсон эхчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдэд илүү хүчтэй нөлөөлж байгаагаас гадна Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ Сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд томоохон сорилт болохоор байгаа нь харагдсан юм.

Хэдийгээр “КОВИД-19” цар тахал, ОХУ - Украйны дайны нөлөөгөөр өрхийн амьжиргаа, бизнесийн орчин тааруу байсан ч өнгөрсөн онд эдийн засаг өсөлттэй гарав. Өнгөрсөн онд гадаад худалдааны эргэлт нэмэгдсэнээр худалдааны тэнцэл 3.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан бол эдийн засаг өмнөх онтой харьцуулахад 4.8 хувиар өсөв.

Хэдийгээр эдийн засагт өсөлт ажиглагдсан боловч төгрөгийн ам.доллартай харьцах ханш тасралтгүй суларч, инфляцын түвшин жилийн туршид 10 хувиас дээш хадгалагдсан өрхийн амьжиргааг доройтуулах

гол хүчин зүйл болов. Түүнчлэн, Монгол Улсын эдийн засаг цөөн тооны хэдхэн салбараас хэт хамааралтай, гадаад орчны нөлөөнд хэт мэдрэг байгаа нь эдийн засгийг төрөлжүүлэх нь нэн чухал байгааг харууллаа.

Нийгмийн үзүүлэлтүүдийг авч үзвэл ядуурал аажмаар буурсан ба 2016 онд ядуурлын түвшин 29.6 хувь (2020 оны түвшинтэй харьцуулахад 1.8 хувиар их), харин 2018 онд 28.4 хувь (2020 оны түвшинтэй харьцуулахад 0.6 хувиар их) байсан бол 2020 онд 27.8 хувь хүрч буурсан байна. Хэдийгээр ядуурлын түвшин буурсан ч Жини индекс буюу орлогын тэгш бус хуваарилалтын индекс 2020 онд 0.32 байсан бол 2022 онд 0.34 болж өсжээ.

2021 оны байдлаар дэлхийн жендэрийн эрх тэгш байдлын индексээр Монгол Улс 191 орноос 76 дугаарт жагссан нь эрх тэгш байдлыг хангахад тууштай ахиц гаргаж байгааг харуулсан бол хүний хөгжлийн индексээр Монгол Улс олон улсад 96 дугаарт жагссан нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлт боллоо.

ын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого” болон цар тахлын дараах сэргэлтэд чиглэсэн бодлогыг боловсруулан, хэрэгжүүлж эхэлсэн. Мөн тус онд Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ) шинээр байгуулагдсан ба цахим шилжилтийн үндэсний стратегийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай”, “Кибер аюулгүй байдлын тухай” зэрэг хуулиудыг шинээр санаачилж, нэмэлт өөрчлөлт оруулан баталсан.

Өнгөрсөн онд залуучуудын манлайлсан тайван жагсаалт хэд хэдэн удаа болж өнгөрлөө. Тухайлбал, өнгөрсөн 4 дүгээр сард Сүхбаатарын талбайд мянга мянган залуучууд цуглан, улс орны хөгжилд тулгараад байгаа асуудлуудад Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа шийдэл болж чадахгүй байгааг шүүмжлэн жагссан бол 12 дугаар сард өрнөсөн жагсаалын гол зорилго нь хууль бусаар их хэмжээний хөрөнгө завшсан, “Нүүрсний хулгайн” хэргийн эздийг олон нийтэд ил болгох, хариуцлага тооцохыг шаардсан жагсаал болж өнгөрсөн юм. Жагсагчид авлига хээл хахууль, төр засгийн үйл ажиллагааны үр ашиггүй байдал, шударга бус байдал, санхүүгийн дарамт, үнийн өсөлт, инфляцыг хөндөн эсэргүүцлээ илэрхийлсэн. Тэд төр засгийг хариуцлагаа дээшлүүлэх, ардчилсан засаглал, ил тод байдлыг нийгэмд бий болгохыг шаардсан юм.

¹ <https://dashboards.sdgindex.org/rankings>

² <https://www.1212.mn/mn>

³ <https://www.1212.mn/mn>

⁴ <https://www.1212.mn/mn>

⁵ <https://www.1212.mn/mn>

⁶ <https://www.1212.mn/mn>

⁷ <https://hdr.undp.org/data-center/thematic-composite-indices/gender-inequality-index#/indicies/GII>

⁸ <https://hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG>

⁹ <https://dashboards.sdgindex.org/>

2 БҮЛЭГ

НҮБ-ын 2017-2022
ОНЫ ХӨГЖЛИЙН
ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗАМААР ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН
ТЭРГҮҮЛЭХ
ЗОРИЛТУУДАД
ХҮРЭХЭД НҮБ-ын
ХӨГЖЛИЙН
СИСТЕМЭЭС
ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ



2.1 НҮБ-ын ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНИЙ (ХТХ) ҮР ДҮН




2022 оны 8 сард Монгол Улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүхийн урилгаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш 2022 оны 8 сард Монгол Улсад айлчлав.

Өнгөрсөн онд НҮБ-ын Удирдлагын багаас ХТХ-ний хэрэгжилтийг хангаж, зорилтот үр дүндээ хүрэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гарган ажилласан ба дараагийн таван жилд буюу 2023 - 2027 онд хооронд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)" бичиг баримтыг эцэслэн боловсруулж, 2022 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газартай хамт гарын үсэг зурж баталгаажууллаа.

ХТХ-ний хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланд дурдсанаар тус бичиг баримт нь Монгол Улсын хөгжлийн үндсэн зорилтуудтай нийцэж, үндэсний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна. ХТХ-г хэрэгжүүлсэн сүүлийн зургаан жилд НҮБ Монгол Улсад үндэсний тэргүүлэх зорилгууд болон ТХЗ-уудад хүрэхэд дорвитой хувь нэмэр оруулж, төрийн бодлого, стратегийг боловсруулах үндэсний чадавхыг бий болгож, нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаа.

ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛЭЭР НИЙТ ЗАРЦУУЛАЛТ, САЯ АМ ДОЛЛАР



Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын үзүүлж буй зөвлөн туслах үйлчилгээ, оролцогч талуудын хамтын хүчин чармайлтыг өрнүүлэх, олон улсын мэдлэг, чадварыг Монгол Улсад нэвтрүүлэхэд хуримтлуулсан олон жилийн туршлагыг өндрөөр үнэлдэг билээ. ХТХ-г хэрэгжүүлсэн хугацаанд Монгол дахь НҮБ-аас үндэсний болон аймаг орон нутгийн хэмжээнд иргэдийн гарт хүрч, хөрсөнд буусан энгийн төслөөс эхлээд улс орны стратегийн шинжтэй томоохон асуудлуудыг хамарсан нийтдээ 216 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд Монгол дахь НҮБ-ын системийн байгууллагууд 239.8 сая ам долларын хөрөнгийг татан төвлөрүүлж, 212.8 сая ам долларыг зарцуулж,

нийт зарцуулалт 88.7 хувийн гүйцэтгэлтэй байлаа.

Монгол дахь НҮБ-аас Монгол Улсын ТХЗ-уудыг хангахад хүчин чармайлт гарган, тууштай хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Тэдгээрийн дотор ялангуяа ядуурлыг бууруулах (ТХЗ-1), өлсгөлөнг эцэс болгох (ТХЗ-2), эрүүл мэндийг сайжруулах (ТХЗ-3), зохистой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих (ТХЗ-8), уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах (ТХЗ-13), зорилго зорилтуудын төлөө түншлэл хамтын ажиллагааг дэмжих (ТХЗ-17) зорилтуудад голчлон анхаарч "КОВИД-19" цар тахал болон бусад амаргүй цагт шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хамтран ажиллалаа.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ 2017-2022

212.8 сая ам доллар

10.4



ТХЗ 1

14.8



ТХЗ 2

79.2



ТХЗ 3

9.8



ТХЗ 4

15.1



ТХЗ 5

3.6



ТХЗ 6

1.1



ТХЗ 7

11.9



ТХЗ 8

9.5



ТХЗ 9

3.4



ТХЗ 10

3.7



ТХЗ 11

7.7



ТХЗ 12

12.8



ТХЗ 13

8.4



ТХЗ 14

9.2



ТХЗ 15

11.3



ТХЗ 16

2.2 НҮБ-ын ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ, ГАРЦ

ГОЛ ҮР ДҮН:



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1:

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 он гэхэд ядуу болон эмзэг бүлгийн хүн амын гэнэтийн гамшгийг даван туулах чадвар нэмэгдэж, хүртээмжтэй өсөлт, эрүүл экологийн тогтолцооны үр шимийг хүртдэг болсон байна.

Тахь-Пржевальскийн адуу нь Монголын говь хээр, тал нутагт амьдардаг ©НҮБХХ



Хамтрагч байгууллагууд:



НҮБ-ын төсөл, хөтөлбөрүүд нь Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлт, тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Энэ хугацаанд НҮБ-ын системийн 13 байгууллага үндэсний хэмжээнд нийт 106.1 сая ам долларын санхүүжилт бүхий 128 төсөл хөтөлбөрийг хамтрагч талуудын оролцоотой хэрэгжүүллээ.

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн хугацаанд НҮБ-ын дэмжлэгийн хүрээнд гарсан онцлох үр дүнгээс дурдвал: хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд i) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай шинэчилсэн хууль батлагдсан, ii) Нагоягийн протоколын дагуу генетикийн нөөц ашиглалтын үр шимийг тэгш хүртэх боломж олгосон Генетикийн нөөцийн тухай хууль, iii) Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төслийн боловсруулахад техникийн туслалцаа үзүүлсэн, iv) Ургамал хамгаалал, холбогдох стандартын тухай олон улсын конвенцын дагуу Монгол Улсын Ургамал хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулах, v) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай шинэчилсэн хууль тус тус гарсан.

НҮБ-аас олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмуудтай нийцсэн ой, ус, газрын тогтвортой менежментийг оруулан байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын талаарх бодлого, зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. ТХГН-ын хууль тогтоомж, экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээ зэрэг хэд хэдэн санал санаачилга нэвтрүүлсэн нь олон эерэг үр дүнг харуулж байна.

ҮЗҮҮЛЭЛТ


	Үндэсний эрчим хүчний тогтолцоонд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлэх	Ахицтай
	Ойн газар, сая га (эсвэл нийт талбайд эзлэх ойн талбайн %)	Хангагдсан
	Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	Хангагдсан
	ДНБ-д эзлэх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувь	Ахицтай
	Гамшгийн нөлөө – гамшгаас үүдэлтэй эдийн засгийн хохирол	Ухарсан
	Ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь	Ухарсан
	Ажилгүйдлийн түвшин	Ухарсан

Тайлбар:

- Хангагдсан - Бодит гүйцэтгэл тухайн зорилтод түвшиндээ хүрсэн, түүнээс дээш байгаа.
- Ахицтай - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс дээгүүр, гэхдээ зорилтод түвшиндээ хүрээгүй
- Ухарсан - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс доогуур байгаа.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1:

106.1 сая ам доллар



Тухайлбал ТХГН-ын хамрах талбай 2015 онд нийт нутаг дэвсгэрийн 17.4 хувийг эзэлж байсан бол 2021 онд 20 хувь болж нэмэгдсэн.

Далайд гарцгүй хөгжиж буй улсуудын Засгийн газар хоорондын байгууллагыг анх удаагаа байгуулсан нь эдгээр улсуудын ашиг сонирхлоо илэрхийлэх, мэдлэг, туршлагаа хуваалцах гол платформ болж хөгжлөө.

ГАРЦ 1.1

ТХЗ-уудтай уялдаж, үндэсний/орон нутгийн түвшинд ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх, эрсдэлийг даван туулах чадвартай болоход чиглэсэн хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, стратеги, төлөвлөгөөг боловсруулах

НҮБ-аас ТХЗ-уудтай нийцсэн бодлогын орчин бүрдүүлэхэд уялдаа холбоо бүхий төсөл, хөтөлбөрүүдээрээ дамжуулан Засгийн газарт үзүүлэх дэмжлэгээ тасралтгүй хүргэж ирсэн. Тухайлбал, үрдүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг үр дүнтэй нэвтрүүлж, 2022 оны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот долоон хөтөлбөр зэрэг ойрын болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулахад уг аргачлалыг ашигласан. Түүнчлэн НҮБ-аас Шинжлэх ухаан, технологийн мастер төлөвлөгөө (2007-2020), хөдөө аж ахуйн салбарын дунд хугацааны бодлогын стратегийн хэрэгжилт зэрэг салбарын бодлогын баримт бичгүүдийг ТХЗ-уудтай уялдуулан шинэчлэх, улмаар 2020 оноос хэрэгжүүлэх төлөвлөгөөг илүү шинэлэг, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүллээ.

Монгол Улс тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилгууд болон ТХЗ-уудад нөөцийг дайчлах, нийцүүлэх, хөшүүрэг болох үндсэн хэрэгсэл болсон Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги (ҮСНС)-ийн төслийг НҮБ-ын дэмжлэгтэй боловсруулж, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо (ТХҮХ) тус төслийг баталсан нь Монгол Улсыг ҮСНС-ийг түүчээлэн нэвтрүүлж, хэрэгжүүлж буй улсуудын нэг болгосон юм. Улсын төсвийн залуучуудад чиглэсэн үйл, ажиллагааны зарцуулалтад үнэлгээ хийсэн нь залуучуудын дуу хоолойг төсвийн төлөвлөлтөд тусгах боломжийг анхлан бий болгосон юм. Улсын төсөв, төвлөгөө гаргах нь төрийн байгууллагуудын үндсэн ажлын нэг боловч төсвийн ил тод, хариуцлагатай байдалд тавих бодит хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор НҮБ иргэний нийгмийн

байгууллага (ИНБ)-уудыг төсвийн хяналт, үнэлгээ (мониторинг) явуулахад нь дэмжлэг үзүүлэв.

НҮБ-аас ядуурлын түвшинг хэмжих, ТХЗ-уудын хэрэгжилтэд гарч буй өөрчлөлт болон “КОВИД-19” цар тахлын нөлөөнд хяналт тавихад үзүүлсэн дэмжлэгийн хүрээнд үндэсний мэдээллийн сан, хяналт үнэлгээний тогтолцоо сайжирлаа. Тухайлбал, нийгмийн бүлэг бүр, ялангуяа эмзэг болон нэн хүнд нөхцөлд амьдарч буй иргэдийн нөхцөл байдлыг тогтоох олон хэмжээст ядуурал (ОХЯ)-ыг тооцох аргачлалыг НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан. Өгөгдлийн сан бүрдүүлсэн өөр нэгэн томоохон ажил бол олон үзүүлэлт бүхий түүвэр судалгаа (ОУТС) бөгөөд тус судалгаагаар ТХЗ-ын зорилтот үр дүнгийн 178 үзүүлэлтийг хэмжиж гаргах боломжтой болсон юм. Хүн амын шилжилт хөдөлгөөний хяналтын матриц (ШХХМ)-ийн үнэлгээ богино ба түр хугацаагаар шилжин суурьшсан хүн амын мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх шинэ аргачлалыг нэвтрүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа.

ГАРЦ 1.2

Шинэ ажлын байр, ур чадвар, чадавхыг бий болгох үндэсний ногоон эдийн засгийн стратеги, байгальд ээлтэй технологийг хөгжүүлэх, байгаль орчны эрсдэл болон ядуурлыг бууруулах (хөдөө болон ойн аж ахуй, уул уурхай, аж үйлдвэрлэл зэрэг салбарт) зэрэг Монголын нөхцөлд нийцсэн, ард иргэдэд тулгуурласан уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, нөлөөллийг бууруулах арга, аргачлалыг нэвтрүүлэх

НҮБ-аас олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмуудтай нийцүүлэн байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын талаарх бодлого, зохицуулалтын таатай орчин бүрдүүлэхэд, нэн ялангуяа ой, ус, газрын тогтвортой менежментийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. ТХГН-ын хууль тогтоомж, экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээ зэрэг хэд хэдэн санал, санаачилгыг гаргасан нь олон эерэг үр дүнг дагуулж байна. Тухайлбал, ТХГН-ын хамрах талбай 2015 онд нийт нутаг дэвсгэрийн 17.4 хувийг эзэлж байсан бол 2021 онд 20 хувь болж нэмэгджээ.

НҮБ-аас Парисын хэлэлцээрт заасан Ил тод байдлыг сайжруулах тогтолцооны хүрээнд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (УАӨСК)-д тайлан, мэдээ бэлтгэхэд төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн.

Үүний үр дүнд Монгол Улс хүлэмжийн хийн ялгаруулалт (ХХЯ)-ын бүртгэл, Хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт (MRV)-ын тогтолцооны аргачлалыг системтэй нэвтрүүлээд байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй зэрэг бусад газар ашиглалтын салбарын ХХЯ, тэдгээрийн эх үүсвэр, шингээлтийн бүртгэл тооллого, явцын хяналтад шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулж, Монгол Улсын Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (NDC)-ыг тайлагнадаг болсон. Монгол Улсын Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг 2019 онд 22.7 хувьд хүргэн өсгөсөн.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөр боловсруулах, түүнд тусгагдах элемент, бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох ажил НҮБ-ын арга зүйн дэмжлэгтэй хийгдэж байна. Аймаг орон нутгийн түвшинд ойн санг нөхөн сэргээн ойжуулах, булгийн эхийг хамгаалах, усан сан байгуулах, онцгой байдлын үед ашиглах малын тэжээлийн агуулахын барилга байгууламж барих зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

НҮБ-аас хот, төв суурины агаарын бохирдлын олон талт асуудлыг шийдэхэд төр засагт дэмжлэг үзүүлж ирсэн. Тухайлбал, агаарын чанарыг сайжруулах зорилгоор монгол гэрийн халаалт, дулаалгын багц (CHIP) зэрэг шинэлэг шийдлүүдийг туршин, агаарын бохирдлын асуудлаар баримтлах бодлогыг сайжруулахад баримт, нотолгоогоор хангахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Гэрт амьдардаг өрхүүдэд халаалт, дулаалгын багцын санхүүжилтийг хүртээмжтэй, үнэ өртгийн хувьд боломжтой байлгах үүднээс Засгийн газраас ногоон зээлийн жилийн хүүг 8-аас 3 хувь болгож бууруулсан.

НҮБ-аас Озоны давхаргыг озон заглагч бодисуудаас хамгаалах тухай Монреалийн протокол болон Мөнгөн усны хэрэглээний тухай Минаматагийн конвенцын гишүүн орны хувьд Монгол Улсад эдгээр асуудлуудын хүрээнд дэмжлэг үзүүлэн ажилладаг билээ. Засгийн газраас гидрохлорфорт нүүрстөрөгч төрлийн бодисын хэрэглээг үе шаттай бууруулах зорилтоо биелүүлж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хэрэглээг 35 хувьд хүргэж бууруулсан байна.



Залуучууд уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөллийг сааруулахад манлайлан оролцож байна. НҮБ-ын дэргэдэх Залуучуудын зөвлөх хорооны гишүүд мод тарих аянд оролцож байгаа нь. ©НҮБ-ын СЗГ

ГАРЦ 1.3

Орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээний хамгааллыг бэхжүүлэх

НҮБ-аас хөрсний доройтлыг бууруулахад үзүүлж буй дэмжлэг нь байгалийн нөөцийн удирдлагыг нэгдсэн, цогц арга барилаар хангах, хөрсний доройтлыг бууруулах дэлхий нийтийн хүчин чармайлтад чухал хувь нэмэр оруулж байна.

Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, ухаалаг мал аж ахуй эрхлэх, малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх талаар малчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд нэлээдгүй ажил хийгдээд байна. Эдгээрийн үр дүнд өнгөрсөн жилүүдэд НҮБ-аас мал аж ахуй, газар тариалангийн голлох бүс нутаг болох 40 суманд мах, цагаан идээ, хүнсний ногоо, зөгийн аж ахуйн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээ бүхий нийт 2,213 ажлын байрыг шинээр бий болгоход хувь нэмэр орууллаа.

Монгол орны ойн ландшафтын бүтээмжтэй, тогтвортой менежментийг хангахад төрийн ба төрийн бус байгууллагууд, ойн нөхөрлөлүүдэд экосистемийн олон талт үйлчилгээний урсгал, тэдгээрийн үр шимийг хадгалан хамгаалахад дэмжлэг үзүүллээ. Энэ хүрээнд гарсан нэг ололт нь 2021 онд ойн газрын бүрхэвч 11 сая га-гаас 14.1 сая га болж өссөн явдал байлаа.

НҮБ-аас орон нутгийн иргэдэд түшиглэсэн эко болон соёлын аялал жуулчлалыг дэмжин орон нутгийн төр засгийн байгууллага болон бусад талуудтай хамтран ажиллаж ирсэн. “Гэр ба байгаль” хөтөлбөрийн хүрээнд иргэдийн бүлэг, нөхөрлөлийг соёлын өв уламжлалаа жуулчдад таниулах, сонирхолтой, адал явдал бүхий аялал, жуулчлалыг хөгжүүлэх дээр хувийн хэвшилтэй хамтран хөрөнгө оруулалт татаж, технологийн дэвшлийг ашиглахад туслалцаа үзүүлэн ажиллаж байна.



ХАА-ын үзэсгэлэнд оролцож буй Д. Улаалзгана STREAM төслийн зохицуулагч А. Амгалангийн хамт ©НҮБ-ын ХХААБ

Д.УЛААЛЗГАНА:

АМЖИЛТ АРВИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОРШОО

Д.Улаалзгана Хэнтий аймгийн Биндэр суманд мал маллаж амьдардаг. Малчин айлд төрж, өссөн тэрбээр мал аж ахуйг өрсөлдөх чадвартай бизнес болгохыг зорин ажиллаж байна. Сүү цагаан идээг зөвхөн уламжлалт аргаар боловсруулах нь хадгалах, зах зээлд нийлүүлэх тал дээр учир дутагдалтайг тэр сайн мэднэ. Малчид хоорондоо хоршин, уламжлалт аргыг орчин үеийн технологитой хослуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өртгийн сүлжээний нэг хэсэг болох нь тэдний хувьд амьжиргаагаа сайжруулах нэн чухал арга зам юм.

ЕХ-ны санхүүжилтээр ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” төслийн дэмжлэгтэйгээр Д.Улаалзгана болон нутгийн бусад малчин эмэгтэйчүүд хамтран хоршоо байгуулж, сүү боловсруулах бага оврын цех байгуулсан. Төслийн хүрээнд тус хоршоонд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, мал аж ахуйн бүтээмжит чанарыг сайжруулах чиглэлээр холбогдох сургалтыг зохион байгуулжээ. Түүнчлэн тус эмэгтэйчүүдийн хоршоог сумын сургуулийн “Үдийн хоол хөтөлбөр”-тэй холбож өгснөөр тэд сүү, цагаан идээгээ орон нутгийн сургуульдаа нийлүүлдэг болсон.

“Хүүхдүүдийн амтархан дурладаг манай үйлдвэрийн зөгийн балтай сүү, ванилийн амттай аарц, исгэсэн ундаа, зөөхий, тараг зэрэг бүтээгдэхүүн нь хүүхэд багачуудын шим тэжээл, эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө гэж бид их баяртай байгаа” гэж хоршооны ахлагч Д.Улаалзгана сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Ийнхүү мал аж ахуйд суурилсан өртгийн сүлжээг хөгжүүлж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэгчийн нэг болж байгаа Д.Улаалзгана, хоршооныхоо ирээдүйг өөдрөгөөр харж байна.

ГАРЦ 1.4

Нутгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадвар сайжирсан байх

НҮБ-аас Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-т зуд, гамшгийн нөлөөг малчид, үндэсний хэмжээний салбарын албан хаагчдад урьдчилан мэдэгдэж сэрэмжлүүлэх ажил дээр дэмжлэг үзүүлсэн. НҮБ-аас “Зудын аюулыг даван туулах, бэлтгэлтэй байх” хөтөлбөрөөр дамжуулан ОБЕГ, Ус цаг уур, орчны шинжилгээний газар (УЦУОШГ)-т байгалийн гамшигт үзэгдлийн (ган, зуд) хяналт (мониторинг), эрт сэрэмжлүүлгийн өнөөгийн тогтолцоо, чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлсний зэрэгцээ гамшгийн нөлөөг урьдчилан мэдээлдэг автомат төхөөрөмжийг нэвтрүүлээд байна. ОБЕГ гамшгийн эрсдэлийг бууруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг гол хөшүүрэг болгон ашигласны үр дүнд томоохон гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хиймэл дагуулаас тухайн

байршилд, цаг алдалгүй өндөр нарийвчлалтай сансрын зураг хүлээн авах боломжтой болсон.

НҮБ-ын зүгээс “КОВИД-19” цар тахлын эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй авч халдвар нийтээр тархах үед төрөөс авч хэрэгжүүлэх бүс, нутгийн үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулсан эрүүл мэндийн болоод салбар дундын баримтлах төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Цар тахлын эсрэг нэн тэргүүнд авах арга хэмжээнд НҮБ-аас цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тэргүүн шугамд ажиллаж байгаа ажилтнуудыг хамгаалах хэрэгслээр хангах, халдварыг цаг алдалгүй оношилдог байхад дэмжлэг үзүүлэн полимеразийн гинжин урвал (PCR)-ын лабораторийг стратегийн бүс нутаг дахь аймгуудад байгуулж, нийгмийн ажилтнуудын цахим мэдээллийн системийг бий болгож, бүх ажилтнуудыг цахим шилжилтэд ороход дэмжлэг үзүүлсэн.



Базаргарьд ажлын байран дээрээ. © ОУШХБ

БАЗАРГАРЬДЫН ТҮҮХ:

АЖИЛТАЙ БАЙХ Л ГОЛ ЗОРИЛГО БАЙВ.

Зуднаар хамаг малаа алдсан аавыгаа хараад бяцхан хүү Г.Базаргарьд “том болоод ажил мэргэжилтэй болж, аавдаа ачааны машин дүүрэн өвс явуулна даа” гэж өөртөө амлаж байжээ. Тэрээр дунд сургуулиа дүүргээд Улаанбаатар хотод шилжин ирж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд гагнуурчны мэргэжил эзэмшин, барилгын салбарт ажиллаж эхэлсэн ч, ажилд орох бүрд анх тохирсон цалингаасаа ихэвчлэн бага цалин авч, зарим нь бүр цалингаа өгдөггүйгээс үүдэн дараагийн ажлаа хайж эхэлдэг байв. Энэ нь хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирсэн иргэдэд тохиолддог нийтлэг бэрхшээл юм.

Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын хэрэгжүүлсэн “Шилжин суурьшигчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” -ийн тухай Г.Базаргарьд өөр нэгэн шилжин суурьшигчаас сонсоноор хөтөлбөрт хамрагдсан юм. 24 настай тэрээр ажилд ороход шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлж, ажлын байрны зөөлөн ур чадваруудыг суралцаж,

“Өмнө нь мөрөөдөж ч зүрхэлдэггүй байсан ажилдаа орох итгэл, зориг нэмэгдсэн” хэмээн ярьсан юм. Г.Базаргарьд одоо Дулааны цахилгаан станцад ажиллаж байна.

Төрийн бус байгууллагуудаар дамжуулан шилжин суурьшигчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий энэхүү хөтөлбөр нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр 10 аймаг, Улаанбаатар хотод хэрэгжсэн бөгөөд нийт 22,504 иргэд хамрагдснаас 14,372 нь эмэгтэй, 444 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Хөтөлбөр нь шилжин суурьшигчдад шилжин очсон газраа дасан зохицох, суурьшихад шаардлагатай бүхий л төрлийн дэмжлэгүүд, тэр дундаа бичиг баримт бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жижиг бизнес эхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг мэдээлэл, үйлчилгээг үзүүлсэн.

НҮБ-аас Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдыг үер усны эрсдэлээс хамгаалахад үерийн хамгааллын 5 далан байгуулж, хамгийн эмзэг 10 хорооны 20,000 гаруй оршин суугчдыг үер усны аюулаас урьдчилан хамгаалж, тэдний амьдрах орчинд эрсдэлийг даван туулах, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Энэхүү НҮБ-ын дэмжлэгийн хүрээнд гэр хорооллын 221.9 га орчим талбай үерийн эрсдэлээс хамгаалагдаж, 3,419 өрх эрсдэлийг даван туулах чадвараа сайжруулаад байна.

НҮБ-аас “Сайн дураараа эх орондоо эргэн ирэхэд туслах” хөтөлбөрийн хүрээнд “Ковид-19” цар тахал гарснаас хойш нийт 37 улсад гацаад байсан 1,300 монгол иргэдийг аюулгүй, зохион байгуулалттайгаар эх орондоо буцаж ирэхэд нь тусламж үзүүлсэн. Зөвхөн 2022 онд гэхэд НҮБ-аас тус хөтөлбөрөөр дамжуулан нийт 11 орноос 499 иргэд (эрэгтэй 239, эмэгтэй 260)-ийг эх орондоо эргэн ирэхэд туслаад байна.

АРИУНСАЙХАНЫ ТҮҮХ:

САЙХАН ХОТЫГ БУЙ БОЛГОХЫН ТУЛД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ХЭРЭГТЭЙ

Булганаагийн Ариунсайхан 2-15 насны 5 хөвгүүний ээж бөгөөд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд тогоочоор ажилладаг. Тэрээр өдрийн 8 цагийн ажилтай, завгүй ээж, гэрийн эзэгтэй ч “Хамтын хүч-27” бүлгийн ахлагчаар ажилладаг. Ариунсайхан нь НҮБ-ын Хабитатын Улаанбаатар хотын гэр хороололд хэрэгжүүлсэн “Үерийн эрсдэлийг бууруулах, даван туулах чадварыг сайжруулах” төслийн хүрээнд 2019 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байгуулагдсан 11 анхдагч бүлгийн нэгийг нь ахлагч билээ. Тэрээр төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад хамрагдан гамшгийн бэлэн байдлыг хангах арга ажиллагааны сургагч багш болж 64 хүнийг гамшгийн бэлэн байдал, нөлөөллийг бууруулах сэдвээр сургасаны ихэнх нь эмэгтэйчүүд юм. Сургагч багш, бүлгийн ахлагч болсон нь түүнийг хувь хүний хувьд хөгжүүлж хүнтэй харилцах ур чадвар нь сайжирсан байна. Алслагдсан гэр хороололд амьдардаг 5 хүүхдийн ээж түүний хувьд өмнө нь ингэж бусадтай харилцаж, арга хэмжээнд оролцох боломж гарч байсангүй. Төсөлд хамрагдан, бүлэг ахалдаг болсон нь түүнд бусдад өөрийн санаа, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөртөө итгэлтэй болоход нь маш их тусалсан байна. Ийм чадваруудыг олж авсан нь түүний хувьд хүүхдүүддээ сайн үлгэр дуурайлал болоход тусалжээ.

“Ер нь эмэгтэйчүүд сурч, чадавхжсанаар хүүхдүүддээ болон олон нийтэд сайн сайхан ирээдүйг бий болгож чадна гэж би боддог” гэж Ариунсайхан хэлж байна.

Тэрээр өөрийн жишээгээр бусад эмэгтэйчүүдийг сурч, мэдлэг чадвартай болж, олон нийтийн ажилд идэвхтэй оролцохыг байнга уриалдаг.



Аюурсайхан (зураг дээр голд нь суугаа) бүлгийн гишүүдийн хамт хорооны иргэний танхимд болж буй уулзалтад оролцож байгаа нь. ©НҮБ-Хабитат

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 он гэхэд ядуу, эмзэг бүлгийн хүн ам нийгмийн илүү сайн хамгаалалтаас ашиг тус хүртэж, чанартай тэгш хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээгээр ялангуяа ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээгээр илүү хангагдсан байна.




Хамтрагч байгууллагууд:



Орон нутгийн иргэд Нэг цэгийн үйлчилгээний төвөөс нийгмийн хамгааллын чиглэлээр үйлчилгээ авч буй нь. ©ОУХБ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:



ГОЛ ҮР ДҮН:



НҮБ-аас ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний үндэсний зорилтод хүрэхэд, “КОВИД-19” цар тахлын үед хүн амыг вакцинжуулалтаар хангах, хүүхэд болон гэр бүлд чиглэсэн арга хэмжээг авах, хүүхэд хамгааллыг сайжруулах болон теле/цахим сургалтыг тасралтгүй хүргэхэд чухал хувь нэмэр оруулсан. Түүнчлэн НҮБ-аас хүн амын хоол, хүнсний шим тэжээлийг нэмэгдүүлэх, тогтвортой түвшинд барих мөн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллалаа.

НҮБ-ын системийн 11 байгууллага 2017- 2022 оны хооронд үр дүнгийн зорилт 2-ын хүрээнд түнш байгууллагуудын хамтаар үндэсний хэмжээнд нийт 59 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, 76.2 сая ам долларыг зарцуулсан байна.

НҮБ-аас үндэсний хэмжээнд усны эх үүсвэрийг сайжруулах хувь хэмжээг 87 хувь, ус ариун цэврийн байгууламжийн нөхцөлийг сайжруулах хувь хэмжээг 70 хувьд тогтвортой байлгахад хувь нэмэр оруулан ажиллалаа. Цар тахлын үед НҮБ-аас төрийн болон хандивлагч байгууллагуудтай хамтран үүссэн нөхцөл байдал, хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээг үндэслэн хүүхэд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн хүмүүсийг хамруулан нийтдээ 2,248,000 хүн (нийт хүн амын 66 хувь)-д цар тахлын эсрэг хариу арга хэмжээг хүргэсэн. Цар тахлын үед Монгол дахь НҮБ-аас хүүхдүүдийг сурч боловсрох нөхцөлөөр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлсний үр дүнд алслагдмал бүсүүдийн болон теле/цахим хичээл үзэх боломжгүй 600,000 гаруй хүүхэд хичээл хийх боломжтой болов.

НҮБ-аас жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, эмзэг бүлгийн иргэдийг оруулан нийт хүн амын хоол тэжээлийг тогтвортой хангах, хүнсний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулахад анхаарч ирсэн билээ. НҮБ-ын техникийн тусламж дэмжлэгтэй i) Таримал ургамлын үр, сортын тухай хууль (2022), ii) Ургамал хамгааллын тухай хууль, iii) Органик хүнсний тухай хуулиудыг шинэчлэн найруулж, баталж, хоол, шим тэжээлийн аюулгүй байдлыг хангах хууль эрхзүйн орчныг сайжруулах ажил хийгдсэн.

Тайлбар:

- Хангагдсан** - Бодит гүйцэтгэл тухайн зорилтод түвшиндээ хүрсэн, түүнээс дээш байгаа.
- Ахицтай** - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс дээгүүр, гэхдээ зорилтод түвшиндээ хүрээгүй
- Ухарсан** - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс доогуур байгаа.

ҮЗҮҮЛЭЛТ



Цар тахлын үед шим тэжээлийн хөтөлбөр үргэлжлэн үндэсний хэмжээнд 5 хүртэлх насны 600,600 гаруй хүүхдэд А амин дэмийг НҮБ-ын дэмжлэгтэй олгосон. Түүнчлэн НҮБ-ын системийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үрдүнд малчдын нийгмийн даатгалын хамрагдалт нэмэгдэж, цочролд шуурхай арга хэмжээ авч бэлэн мөнгөний тэтгэмж олгох замаар нийгмийн хамгааллыг өргөжүүлснээр малчдын амьжиргаа, эрсдэлийг даван туулах чадавх дээшилсэн байна. Малчдын хувьд ч малын тоо толгойг зохицуулж, чанаржуулах зэргээр орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх чадавх дээшилж байна. Хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн туршилтын төслийн үр дүнд үндэслэн цар тахлын хариу арга хэмжээ авах хүрээнд Засгийн газраас хүүхдийн мөнгөн тэтгэлгийг орон даяар хүүхэд бүрт олгож өргөжүүлэв.

ГАРЦ 2.1

Хотын зах болон зорилтот сумдын технологи, ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нотолгоонд суурилан, олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх замаар тэгш байдлаар нэмэгдүүлэх.

НҮБ-ын дэмжлэгтэй уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус, ариун цэврийн байгууламжийн

хангамжийг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл хангах орон нутгийн бодлого, төлөвлөгөөний хүрээнд 9 ухаалаг (автомат) ундны усны худаг, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус, ариун цэврийн байгууламжийг 8 эмнэлэгт бий болгосноор орон нутгийн 22,800 хүн үр шимийг хүртэж байна. Ялангуяа “КОВИД-19” цар тахлын үед ус, ариун цэврийн найдвартай байгууламжтай байх нь халдварын тархалтыг хязгаарлах, бууруулахад нэн чухал байв. Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд, хувийн хэвшлийг оролцуулан хамтын ажиллагаа, түншлэлийн сүлжээ, зохицуулалтыг бий болгож, орон нутагт сургуулиудын ус, ариун цэврийн байгууламжийн нөхцөлийг сайжруулснаар үндэсний болон орон нутгийн институцын чадавх дээшилж байна. Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-наас 2025 он гэхэд үндэсний хэмжээнд бүх хүүхдийн цэцэрлэг, сургууль, дотуур байрны гаднах ариун цэврийн байгууламж (нүхэн жорлон)-ийг үе шаттайгаар хэрэглээнээс гаргахаар ажиллаж байгаа бөгөөд үүнд зарцуулах нийт санхүүжилт 100 тэрбум төгрөг/28.9 сая ам доллар байхаар тооцоолсон байна. Энэ хүрээнд 2022 онд НҮБ-ын шууд дэмжлэгтэй нийт 15 сургууль, цэцэрлэгийн 3,600 гаруй хүүхэд (үүний 1,836 охид) гар угаагуур, шүршүүр бүхий дотор ариун цэврийн байгууламжтай болсон.

АНХИЛУУНЫ ТҮҮХ:

СУРГУУЛИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БОЛГОВ

Завхан аймгийн сурагч 16 настай Анхилуун “Сургуульд ирэхэд хамгийн дургүй болгодог ганц зүйл бол сургуулийн гаднах жорлон байсан. Сургуулиас хол байдаг ч үнэр нь үнэртдэг байв. Өвөл жорлон хөлдөж, халтиргаатай болдог нь сарын тэмдэг ирсэн үед надад үнэхээр хэцүү байдаг байсан” гэв. Завхан аймгийг Монгол орны хамгийн хүйтэн аймгийн нэг гэдэг. Сургуулийн эмч хүүхдүүд гадна бие засах газарт орохгүй байхын тулд ус болон шингэн зүйл маш бага уудаг, үүнээс болж олон хүүхэд эрүүл мэндийн асуудалтай болдог гэж ярьж байв. Хүүхдүүд өвөл хүйтэнд гадуур хувцасгүйгээр гадна жорлонд орсоноос өвдөхөд хүрдэг. Гадна хүхэн жорлонг ашиглах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд илүү хүнд байдаг байсан. Харин НҮБ-ын Хүүхдийн Сан түнш талуудтайгаа хамтран 2022 онд хүүхдүүд, сургуулийн ажилтнуудад сургуулийн барилга дотор ариун цэврийн байгууламжийг шинээр барьж өгсөн. Анхилуун болон түүний найз нар ийм шинэ боловсон бие засах газартай болсондоо маш их баярласан. “Хөгжлийн бэрхшээлтэй бидэнд хүртэл тохирсон бие засах газартай боллоо!” гэж сурагч Дэмбэрэлням өгүүлэв. Энэ санаачилгын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сан тус сургуулийн 500 гаруй сурагч, 70 ажилтныг орчин үеийн ус, ариун цэврийн байгууламжтай болгоод байна. Тус сангаас ийм байгууламжийг үндэсний хэмжээнд дэлгэрүүлэхийг уриалж ажилладаг.

“Одоо би сургуулийнхаа бүх зүйлд дуртай болсон” гэж Анхилуун охин сэтгэл хангалуун байна.

Түүнчлэн НҮБ-аас Улаанбаатар хотын захын дүүргийн эмзэг бүлгийн 7,263 иргэд (үүний 51 хувь эмэгтэйчүүд)-ийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, үер усны эрсдэлээс хамгаалахад дэмжлэг үзүүлэв. НҮБ-аас Улаанбаатар хот руу шилжин суурьшигчдад нэн ялангуяа эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ авахад анхаарал хандуулан ажиллаа.

ГАРЦ 2.2

Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж хот суурин, хотын захын хороолол, хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээнд хүн бүр тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих

Энэ хүрээнд НҮБ-ын хүчин чармайлтаа эрүүл мэндийн үйлчилгээг бэлэн байлгах, үйлчилгээ авах боломжийг хязгаарладаг тогтолцооны сул талууд, нөгөө талаас үйлчилгээ авахыг төдийлөн эрмэлздэггүй иргэд, хувь хүний зан үйлийн төлөвт голлон чиглүүлэв. НҮБ-аас Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын орчныг шинэчлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ (ЭМАШТУ)-г чанартай хүргэх, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ), шинээр байгуулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулах газар (ЭЭХХЗГ)-ын чадавхыг бэхжүүлэхэд голлон анхаарч дэмжлэг үзүүлэв. Өнгөрсөн хугацаанд 2,300 эрүүл мэндийн ажилчдыг шинээр авч ажиллуулах, “КОВИД-19” цар тахлын эсрэг вакцинжуулалтыг нэгдсэн журмаар зохион байгуулж, дархлаажуулалтын нэгж бий болгох, хүүхдийн эрүүл мэнд, өсөлтийн үзлэгийг явуулах, дархлаажуулалтын аянд дэмжлэг үзүүлснээр ЭМАШТУ-ний нэгжээр дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээний цогц байдал сайжирсан. Түүнчлэн ус, ариун цэврийн байгууламжтай холбож, хувь хүний хамгаалах хэрэгсэл, бусад бүтээгдэхүүн агуулах хадгалах сав, эмнэлгийн хэрэгслээр бүрэн тоноглогдсон, эм бэлдмэлийн багц, идэвхтэй холбоос (КОДАН) бүхий 6 явуулын эмнэлэг бий болгож эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлсэн.

Агаарт ялгарах утаа, хийн ялгаруулалтыг бууруулах хүрээнд нэвтрүүлсэн монгол гэрийн халаалт,

дулаалгын ЧИП багцыг илүү олон өрхөд хүргэх үүднээс Засгийн газраас зээлийн хүүг (2022 онд 8 хувиас 3 хувь болгож) бууруулсан нь багцын үнэ өртөг боломжийн түвшинд байх, багцын нийлүүлэлтийн сүлжээ, борлуулалтыг нэмэгдүүлэхэд тусалсан.

НҮБ-аас аймаг орон нутгийн түвшинд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх салбар дундын хороодын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Орон нутаг, сургуулийн орчинд сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөхүүдийг сургаж ажиллуулах зэргээр хүний нөөцийг бэхжүүлэх, сургуулийн дотуур байранд амьдардаг охид болон өсвөр насны охидын сарын тэмдгийн эрүүл ахуйн орчныг сайжруулах зэргээр тусламж үйлчилгээний чанар, агуулгыг сайжруулсан. НҮБ нь стратегийн төлөвлөлтийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, газарзүйн мэдээллийн систем (ГЗМС)-ийн өгөгдлийг ашиглах, алслагдсан газруудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтнуудад зориулсан мэдээллийн суваг, сургалтын хөтөлбөр, агуулга, ашиглах материал, цахим эрүүл мэндийн стандарт хичээлийг эх хэл дээр нь гаргах зэрэг ажилд дундын холбогч болон зөвлөхийн үүрэгтэй оролцож ирсэн. “ТХЗ”-уудыг нэвтрүүлэх, эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх (MAPS) хөтөлбөрийн хүрээнд НҮБ, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хамтарсан санаачилгын үр дүнд бэлгийн боловсролыг сайжруулах, хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн боловсролын асуудлуудад улсын төсвөөс 2019 оны байдлаар 1.4 тэрбум төгрөгийг хуваарилуулж батлуулсан нь өмнөх оны төсөвтэй харьцуулахад 9 дахин нэмэгдсэн үзүүлэлт боллоо.

НҮБ-ын дэмжлэгийн хүрээнд Хавдрын үндэсний төвийн шугаман хурдасгуурт суурилсан туяа эмчилгээний дэвшилтэд технологи (хавдрын эд эсийг үхүүлэх, үржихийг зогсоох)-ийг оруулан хавдрын эмчилгээний үндэсний хөтөлбөрт техникийн тодорхой тусламж үзүүлэв. Энэ хурдасгуурын аппарат толгой, хүзүү, хөх, умайн хүзүү, түрүү булчирхай, нүд зэрэг тодорхой төрлийн хавдрын эмчилгээнд чухал үүрэгтэй төхөөрөмж юм. Цаашилбал, чанарын баталгаа, чанарын хяналтын шаардлагын дагуу технециум-99м генераторыг оруулан анагаахын радио-изотопийг үйлдвэрлэх, бэлтгэх чадавхыг бэхжүүлж, хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн тогтвортой хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлсэн.



Эрүүл аж амьдралыг эрхэмлэж буй Хишигдаваа ©ДЭМБ

ХИШИГДАВААГИЙН ТҮҮХ:

ГЭР БҮЛИЙН ХАЙР ТҮҮНИЙГ ЭРҮҮЛ АМЬДРАЛД ХӨТӨЛСӨН

Дархан-Уул аймгийн иргэн 39 настай Мягмарын Хишигдаваа өмнө нь 85кг биеийн жинтэй, хэт таргалалттай байсан юм. Энэ нь түүний эрүүл бус, муу дадал зуршлаас үүдэлтэй байв. Тэр үргэлж хийжүүлсэн ундаа ууж, шөнө оройн цагаар боловсруулсан хүнс их иддэг байж. Улмаар түүний даралт ихсэн, зүрхний хэм алдагдаж, цусан дахь сахарын хэмжээ өндөр гарах болсон. Хишигдаваа эмчтэйгээ сайтар ярилцсаны эцэст өөрийн идэж буй хоол хүнс, өдөр тутмын амьдралын хэв маягаа өөрчилж, энэхүү халдварт бус өвчинтэйгөө тэмцэхээр шийдсэн байна.

Хишигдаваа дасгал хөдөлгөөн хийж, архи тамхи хэрэглэхээ больсноор шөнө сайн унтаж амран, өглөө эрт босдог болж, илүү их эрч хүчийг мэдэрч эхэлсэн байна. Түүний энэ өөрчлөлтийг гэр бүл, найз нөхөд нь дэмжин, урам өгсний үр дүнд 28 кг хаяж, биеийн жин нь хэвийн хэмжээнд хүрсэн.

“Муу дадал зуршил, эрүүл бус амьдралын хэв маягаа өөрчлөх энэ аяныг эхлүүлэх гол шалтгаан бол миний гэр бүл байсан. Би хүүхдүүддээ сайн үлгэр жишээ үзүүлэхийг хүссэн. Би өөрөө эрүүл, аз жаргалтай болсноор гэр бүл, хайртай хүмүүсээ дэмжин, тэдэндээ бүрэн анхаарал тавьж чаддаг болж байна” хэмээн Хишигдаваа хуваалцлаа.

Таргалттай тэмцэн, цусан дахь сахарын хэмжээгээ бууруулж чадсанаар Хишигдаваа амьдралын хэв маягаа өөрчилж, илүү эрч хүчтэй, эрүүл аав байж, гэр бүлдээ аз жаргал, хайрыг авчирч чадсан. Хишигдаваа өөрийн энэхүү туршлагаа таргалалтаас үүдсэн эрүүл мэндийн асуудалтай хэн бүхэнтэй хуваалцаж, аль болох олон хүнийг муу дадал зуршлаас нь салгахыг хүсч байгаа юм. Тиймээс өөрийн амьдарч буй Дархан сумандаа эрүүл мэндийн клуб ажиллуулан, нутгийн иргэд, клубын гишүүддээ эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маягийн зорилгодоо хүрэхэд нь тусалж байна. Тэрээр “Эрүүл мэнд - эрхэм баялаг” хэмээн хэлэх дуртай.

ГАРЦ 2.3

Илүү чанартай суурь боловсролыг дэмжиж, хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх, улмаар насан турш боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг зорилтот бүлэг, сумдад хэрэгжүүлэх

НҮБ-ын тууштай ухуулга сурталчилгаа, хүчин чармайлтын үр дүнд хүүхдүүдийн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх тэгш сурч боловсрох боломж нэмэгдсэн. Хүүхэд хөгжлийн төв (ХХТ)-үүдээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй 67 хүүхдийг зорилтот газрын 4 сургуульд бүртгүүлж, тэдэнд сурч хөгжих боломж олгосон. Түүнчлэн “Явуулын багш санаачилга” хөгжлийн бэрхшээлтэй 75 хүүхдэд гэрийн сургалтын үйлчилгээ хүргэсэн. НҮБ-аас бага насны хүүхдүүдийг хөгжүүлэхийг чухалчилж бага насны хүүхдийн хөгжлийн төвүүдийг үндэсний хэмжээнд хүүхэд төвтэй интерактив ур чадвар олгох орчныг бүрдүүлж, 0-3 насны хүүхдүүдэд зориулсан Бага насны хүүхдийн хөгжлийн хүртээмжтэй стратеги, хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

Түүнчлэн НҮБ-аас бага насны хүүхдийн хөгжилд эцэг эхийн нь идэвхтэй оролцоог хангахад голлон анхаарч, зорилтот 10 хүүхдийн цэцэрлэгт эцэг эхийн клуб байгуулж, 70 мастер сургагч багш бэлтгэсэн. Эдгээр багш нар эцэг эхийн клубуудын ажиллагаанд хяналт тавьж, сайн практик жишээ, гарсан сургамжийн талаар мэдээлэл цуглуулж, бусад орон нутгийн залуу эцэг эхчүүд болон өвөө эмээ нарт танилцуулж, хуваалцах ажил хийгдлээ. Орон нутгийн эрүүл мэндийн төвийн ажилтнуудын 9, 18, 36 сартай хүүхдүүдийн эрт үзлэг хийх чадавхыг бэхжүүлсэн нь бага насны хүүхдийн эндэгдэл буурах, аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлэх, эмчилгээний зардлыг багасгахад тустай ажил боллоо. Зорилтот 4 аймгийн бүх өрхийн эмнэлгүүдэд хүүхдийн тоглоом, ном болон эрүүл мэнд, хөгжлийн үзлэгт шаардлагатай бусад зүйлийг олгосон. Зорилтот газруудын Бага насны хүүхдийн боловсролын 4 төвийн гал тогоо, ариун цэврийн байгууламжийн орчныг хоол тэжээл болон ус, ариун цэврийн байгууламжийн багуудтай хамтран сайжруулав. Судалгаагаар зорилтот хүүхдийн цэцэрлэгүүдийн 85 хувь нь хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээний шалгууруудыг хангасан гэдэг нь харагдсан байна.

Орхигдох эрсдэлтэй, эмзэг бүлгийн өрхүүдийн хүүхдүүдэд голлон чиглэдэг хүүхдэд ээлтэй 24 цагийн цэцэрлэгүүдийн эрүүл мэнд, хоол тэжээл, ус ариун цэврийн байгууламж, хөгжлийн нэгдсэн тусламж үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролын бүртгэл Баянзүрх дүүрэгт 7 хувиар

өссөн. НҮБ-аас эрүүл мэндийн боловсрол ялангуяа Насан туршийн боловсрол олгох төвүүдийн Бэлгийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн үнэлэхэд үнэтэй дэмжлэг үзүүлэв. Гарсан зөвлөмжүүдийг БШУЯ-нд цаашид бэлгийн боловсролын талаар баримталдаг олон улсын техникийн удирдамжийн дагуу сургалтын хөтөлбөрийн гол контент болгон оруулах зорилгоор хүргүүлэв.

ГАРЦ 2.4

Нийт хүн амыг ялангуяа ядуу, эмзэг бүлгийн хүн амыг түлхүү хамруулсан үр ашигтай, үр нөлөө бүхий нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх

НҮБ-ын системийн байгууллагууд хамтран малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, цочролд хариу үзүүлэх бэлэн мөнгөний тэтгэмж олгох, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх замаар малчдын амьжиргаа, эрсдэлийг даван туулах чадавх дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд туршилтаар төсөл хэрэгжүүлсэн 5 суманд малчдын нийгмийн даатгалын хамрагдалт 10 хувиар нэмэгдэж, цочролын шуурхай хариу үзүүлэн бэлэн мөнгөний тэтгэмжийг 2 долоо хоногт багтан зорилтот бүлгийн иргэдэд олгодог болсон. Түүнчлэн амьжиргааг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилготой 14 жижиг бизнес бий болсон. Засгийн газраас өмнө хэрэгжсэн туршилтын төслийн ололт, сургамжид үндэслэн “КОВИД-19” цар тахлын цочролын хариу арга хэмжээ болгон хүүхдийн мөнгийг орон даяар өргөжүүлсэн.

НҮБ-аас хүн амын шилжилт хөдөлгөөнийг Хөдөлмөрийн зах зээлийн загвар, Дотоод шилжилт хөдөлгөөний математик загварчлал зэрэг арга, аргачлалыг ашиглан баримт, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Шилжилт хөдөлгөөнийг олон талаас нь судалсны үндсэн дээр шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх, Засгийн газрын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болоод бусад бодлогын баримт бичигт тодорхой тусгаж, өгөх шаардлага байгаа нь харагдсан. НҮБ-аас ТББ-ын тусламжтайгаар 50,000 шинээр шилжин суурьшсан иргэдэд шууд дэмжлэг үзүүлснээс гадна үндэсний хэмжээнд 1,000 гаруй орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөний менежментийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн. Түүнчлэн НҮБ-аас Улаанбаатар хотын захын эмзэг бүлгийн 7,263 (51 хувь эмэгтэй) иргэдийн ариун цэврийн байгууламжийн нөхцөлийг сайжруулах, үер усны эрсдэлийг даван туулах чадварыг дээшлүүлэхэд тусалж, 4,000 гаруй шилжин суурьшсан иргэдэд хүрч нотолгоонд суурилсан шилжилт хөдөлгөөний талаар мэдээлэл өгөх аяныг өрнүүлсэн.



Н. Амарбаясгалан нөхөр Д. Батсайханы хамт ©ОУХБ

АМАРБАЯСГАЛАНГИЙН ТҮҮХ:

МАЛЧИН Н.АМАРБАЯСГАЛАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ТҮГЭЭХЭЭР ИДЭВХТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА.

Завхан аймгийн малчин Нийсүрэнгийн Амарбаясгалан нийгмийн даатгал яагаад чухал болохыг өөрийн туршлага, мэдлэгт тулгуурлан бусад малчдадаа түгээж байна. Түүний нөхөр Довоогийн Батсайхан мал маллаж яваад тэмээнээс унаж хөл, гараа гэмтээжээ. Н.Амарбаясгалан нийгмийн даатгалын сургалтад хамрагдсанаар үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг хэрхэн авах тухай олж мэдсэн юм. Өмнө нь Н.Амарбаясгалан 17 жил нийгмийн даатгал төлж байсан ч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хэрхэн авах талаар мэддэггүй байжээ. Н.Амарбаясгалан гэр бүлдээ тохиолдсон энэхүү үйл явдлыг жишээ болгон туршлагаа хуваалцаж, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчилдаг болов.

Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг нь мал аж ахуйг түшиглэж амьдардаг бөгөөд байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөх эрсдэл өндөр. Дэд бүтэц, мэдээллийн хялбар, хүртээмжгүй байдлаас шалтгаалан нийгмийн хамгааллын тогтолцооны үр өгөөжийн талаарх мэдлэг хомс байдаг. НҮБ-ын Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх төсөл нь малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг өргөжүүлэх замаар ядууралд өртөх, байгаль цаг уурын гамшигт үзэгдэлд бэлэн байх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм. Хамтарсан төслийн хүрээнд Завхан аймгийн таван суманд нийгмийн даатгал, түүний ач холбогдлын талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх сургалтыг зохион байгуулж, малчид хоорондоо мэдээллээ солилцох, бие биеэ сургахад анхаарч ажиллалаа.

ГАРЦ 2.5

Хүнс, шим тэжээлийн аюулгүй байдлыг сайжруулах, эрүүл хүнс/хоол тэжээлийн орчныг бүрдүүлэх, хоол тэжээлийн дутагдлын хавсарсан эрсдэлийг бууруулах, хүнс болон шим тэжээлийн тандан судалгаа, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх

НҮБ-аас Засгийн газарт амьтан, ургамлын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотой хууль тогтоомж, бодлого, стандартыг боловсронгуй болгоход үзүүлсэн техникийн тусламжаар дамжуулан хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ирсэн билээ. Энэ хүрээнд Бичил биетний тэсвэржилт (ББТ)-ийн үндэсний хөтөлбөр (2022-2025)-ийг эцэслэн боловсруулж, үндэсний хэмжээний лабораторийн 25 мэргэжилтэн ББТ-ийг тандах судалгааны систем, лабораторийн үнэлгээний хэрэгсэл дээр ажиллах чадвартай болж, хүнсний бүтээгдэхүүний ББТ-ийн асуудлаар чадавх бэхжсэн. НҮБ-ын техникийн тусламжийн хүрээнд Таримал ургамлын үр, сортын тухай (2022), Ургамал хамгааллын тухай, Органик бүтээгдэхүүний тухай хуулиудыг шинэчлэн найруулж, батлан хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгож хүнс, шим тэжээлийн аюулгүй байдлыг хангаж байна. Үндэсний хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээ, хил орчмын мал амьтны өвчлөл, бэлэн байдал, гэнэтийн арга хэмжээний баримтлах стратеги зэргийг боловсруулах, Монгол Улсын эрүүл мэнд нэгдсэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

НҮБ-ын дэмжлэгтэй цар тахлын үед шим тэжээлийн хөтөлбөр үргэлжилж үндэсний хэмжээнд 5 хүртэлх насны 600,609 хүүхдэд А амин дэмийг олгосон нь тухайн цаг үеийн чухал дэмжлэгийн нэг байлаа.

Түүнчлэн НҮБ-аас 35,600 хүүхдийн үзлэг шинжилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлж, 1,719 хүүхэд хоол тэжээлийн цочмог дутагдалтайг тогтоож, амь насыг нь аврах эмчилгээнд оруулж, 46,000 гаруй хүүхэд, эхчүүдэд хоол, шим тэжээлийн талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

НҮБ-ын дэмжлэгтэй бага насны хүүхдүүдийн таргалалт, жингийн илүүдлийн судалгаа явуулсан нь нялх болон бага насны хүүхдүүдийн хооллолт, олон аминдэмт, бичил тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний хөтөлбөрийн үндэсний чадавхыг бэхжүүлэхэд гол суурь болж, сургууль, тэдгээрийн дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн гал тогоо, цайны газрын хоолны стандартыг тогтооход техникийн тусламж үзүүлсэн нь сургуулийн хоолны тэжээллэг чанар сайжрах, Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны тухай хууль хэрэгжихэд дэмжлэг болов. Баяжуулсан хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд оруулсан нэг чухал хувь нэмэр бол баяжуулсан гурил, иоджуулсан давс болон бусад хүнсний бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний аргуудын стандартыг гаргахад Засгийн газарт туслалцаа үзүүлсэн явдал бөгөөд энэ нь хүнсний лабораториудад баяжуулсан хүнсний бичил тэжээлт бодисын агууламжийг шинжилгээний үр дүнгээр баталгаажуулах боломжийг бүрдүүлсэн юм. Уур амьсгалын өөрчлөлтийн хоол хүнс, шим тэжээлийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийсэн нь энэ чиглэлээрх төрийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд тус өөрчлөлтийг нөлөөг авч үзэх шаардлагатайг харуулсан.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3:

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 он гэхэд төрийн удирдах байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжиж, хүн бүрийн нэн ялангуяа орхигдох эрсдэл бүхий бүлгийн эрхийг дээдэлж, ард иргэдийнхээ өмнө илүү нээлттэй байж, хүлээх хариуцлагаа дээшлүүлсэн байна.



Хамтрагч байгууллагууд:



Тогтвортой хөгжлийн зорилго өдөрлөгт оролцсон залуус байгальд ээлтэй, хариуцлагатай хэрэглээг дэмжиж буйгаа илэрхийлэв. ©НҮБ-ын СЗГ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:



ГОЛ ҮР ДҮН:



НҮБ-аас жендэрт суурилсан, гэр бүлийн хүчирхийлэл нэн ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллээс ангид байх, хүний эрхийг хамгаалах, дэмжихтэй холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах, эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт (мониторинг) тавихад дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд НҮБ-ын системийн 9 байгууллага Үр дүнгийн зорилт 3-ын хүрээнд хамтрагч байгууллагуудын оролцоотойгоор үндэсний хэмжээнд 29 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, 30.5 сая ам долларыг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын дэмжлэгтэй хүний эрх ялангуяа охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, дэмжихэд тодорхой хэмжээний ахиц гаргаж байна. Засгийн газраас Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-ийн хүрээнд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлээд байгаа бөгөөд 2020 оны байдлаар дэмжлэг үзүүлсэн зөвлөмжүүдийн хэрэгжилт 89 хувьтай байна.

НҮБ-аас i) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, ii) Хүүхдийн эрхийн тухай хууль, iii) Хүүхэд хамгааллын тухай хууль, iv) Залуучуудын хөгжлийн тухай хууль, v) Монгол Улсын Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, vi) Хөдөлмөрийн тухай хууль, vii) Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн удирдлагын тухай хууль, viii) Улс төрийн намуудын тухай хуулиудыг боловсронгуй болгож, батлуулахад туштай дэмжлэг үзүүлж ирлээ. Түүнчлэн НҮБ-аас "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" ОУХБ-ын конвенц (Дугаар 167)-ийг соёрхон батлахад дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд төр засаг, ажил олгогч байгууллагууд, ажилчдын хооронд хэлэлцүүлэг өрнүүлж, ажилчдад албан бус байдлаас албан байдалд шилжихэд дэмжлэг үзүүллээ.

Тайлбар:

- Хангагдсан** - Бодит гүйцэтгэл тухайн зорилтод түвшиндээ хүрсэн, түүнээс дээш байгаа.
- Ахицтай** - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс дээгүүр, гэхдээ зорилтод түвшиндээ хүрээгүй
- Ухарсан** - Бодит гүйцэтгэл суурь түвшнээс доогуур байгаа.

¹⁰ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенц

¹¹ Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт

¹² Лесби, гей, бисексуал, трансжендэр

ҮЗҮҮЛЭЛТ

- Хүн бүрийн эрхийг хамгаалан, дээдлэх, наад захын эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ХЭТБ-ын илтгэл болон НҮБ-ын олон улсын гэрээ, конвенцуудын /ЭАБХУОУК¹⁰, ЭЗНСЭОУП¹¹ болон бусад/-ийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал **Хангагдсан**
- Бүх төрлийн алагчлалын эсрэг (ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТ¹²) хууль тогтоомжийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлэх. **Хангагдсан**
- УИХ, төв орон нутгийн засаг захиргаа, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь, (ТХЗ 5.5.1) **Ахицтай**

ГАРЦ 3.1

Олон улсын стандартын дагуу холбогдох хуулиудыг шинэчлэн хамгааллын хэм хэмжээ (норматив)-ний механизмуудыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, эмзэг ядуу, орхигдох эрсдэлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад хяналт (мониторинг)-ын механизмыг бүрдүүлж, бэхжүүлэх

Монгол Улс НҮБ-ын дэмжлэгтэйгээр Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хоёр дахь дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-ийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 2020 оны байдлаар дэмжлэг үзүүлсэн 150 зөвлөмжийн бүрэн ба хэсэгчилсэн хэрэгжилтийн биелэлт 89 хувьтай гарсан. Улмаар 2020 онд Монгол Улс ээлжит гурав дахь дүгнэлт хэлэлцүүлгийг явуулж, нийт 190 зөвлөмж өгснөөс 170 зөвлөмжийг дэмжин хүлээн авсан. Засгийн газрын хамтарсан ажлын хэсэг НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2022 онд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-ийн үндэсний гуравдугаар тайланг бэлтгэн гаргаад байна.

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн хугацаанд НҮБ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийн тухай, Монгол Улсын Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн удирдлагын тухай хуулиудын төслийг боловсруулах, шинэчлэн найруулахад дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн НҮБ-аас “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” ОУХБ-ын конвенц (Дугаар 167)-ийг соёрхон батлахад дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд төр засаг, ажил олгогч байгууллагууд, ажилчдын хооронд ярилцлага хэлэлцүүлэг өрнүүлж, ажилчдад албан бус байдлаас албан байдалд шилжихэд дэмжлэг үзүүлэв.

НҮБ-аас Засгийн газарт жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлын судалгааг анхлан явуулахад дэмжлэг үзүүлснээс гадна хамтран амьдрагчийн зүгээс болон, гэр бүлийн хүрээний хүчирхийллийн талаарх судалгааг явуулж, түүний үндсэн дээр шийдвэр гаргалтын түвшинд нотолгоонд суурилсан мэдээллээр хангасны үр дүнд жендэрт суурилсан хүчирхийлэлээс сэргийлэх, хариу арга хэмжээнд 2016 оны байдлаар төсвийн хөрөнгөөс 20 сая төгрөг хуваарилж байсныг 2017-2022 оны хооронд 10 тэрбум төгрөг болгон өсгөсөн.

НҮБ-аас жендэрт суурилсан хүчирхийллийн хариу арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлын үнэлгээг хийхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод анхан шатанд шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэхийг зорив. Засгийн газартай хамтран НҮБ-аас нийт 21 аймагт 17 нэг цэгийн үйлчилгээний төв, 14 хамгаалах байрыг бий болгож, 2017-2022 оны хооронд (“КОВИД-19” цар тахлын үе ороод) 22,268 жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна. Нэг цэгийн үйлчилгээний 6 төвд эмэгтэйчүүдийн эдийн засгийн бие даасан байдлыг дэмжих санаачилгыг нэвтрүүлж, хүчирхийллийн хохирогчдыг эдийн засгийн хараат бус байдалд хүрэх, хүчирхийллийн мөчлөгийг таслах зорилготой туршилтын төсөл хэрэгжүүлсэн ба эдгээр төслүүдийн үр дүн эерэг, цаашид өргөжүүлэх боломжтой байгаа нь харагдсан. Түүнчлэн төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг НҮБ-ын дэмжлэгтэй боловсруулсан нь Төрийн албаны зөвлөл (ТАЗ)-ийг

хөдөлмөрийн дотоод журамд гомдол барагдуулах механизмын стандартыг оруулан Ажлын байран дахь бэлгийн дарамт мөлжлөгөөс сэргийлэх удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих боломж олгосон.

Цаашилбал Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран НҮБ-аас үндэсний хэмжээнд охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийлэл, хүний наймааны хохирогч болохоос хамгаалах, сэргийлэх аяныг амжилттай өрнүүлсэн нь 6.6 сая хүн (мэдээллийн олон сувгуудаар дамжуулсан, давхардсан тоогоор)-д хүрсэн байна.

НҮБ-аас Цагдаагийн ерөнхий газрын дэргэд үндэсний хэмжээнд жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг бүртгэж, мэдээлэх жендэрт суурилсан хүчирхийллийн цахим мэдээллийн санг байгуулж, ажиллуулахад дэмжлэг үзүүлсэн. Тус мэдээллийн санд 2017-2022 оны хооронд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 7,738 гэмт хэргийн тохиолдол, 49,078 зүй бус үйлдэл бүртгэгдэж, мэдээллийн сангаар дамжуулан жендэрт суурилсан хүчирхийллийг байршил, хэлбэрээр задалсан тоон мэдээ мэдээлэл гаргах боломжтой болсон.

ГАРЦ 3.2

Монгол Улсын Их хурал, яам, төрийн нарийн бичгийн дарга нарын алба, орон нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчид зэрэг шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд болон залуучууд (жишээ нь 34 нас хүртэлх)-ын төлөөллийг нэмэгдүүлэх

Орон нутгийн зөвлөл хороод (Иргэдийн төлөөлөгчдийн хурал)-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ 2020 оны сонгуулийн дараа 28 хувь хэвээр байсан нь бүс нутгийн дундаж (33 хувь)-аас доогуур байна. НҮБ-аас хууль санаачлагчдыг улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж буй олон улсын сайн туршлага, нөлөөллийн үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, Улс төрийн намуудын тухай хуулийг шинэчлэхэд тууштай дэмжлэг үзүүлж ирсэн. Тус ажлыг хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог хангасан хууль, тогтоомжийн шинэчлэл хийхэд олон улсын хандивлагч байгууллагуудыг татан оролцуулах, талуудын оролцоо, идэвхийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулан ажиллаа.

ДЭЛГЭРИЙН ТҮҮХ:

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН ЗАМ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙНХЭЭС ИЛҮҮ БАРТААТАЙ



Дэлгэр бол Булган аймгийн хэмжээнд байдаг хоёр эмэгтэй сумын Засаг даргын нэг төдийгүй сумынхаа анхны эмэгтэй Засаг дарга юм. Мөн тэрээр Булган аймгийн ИТХ-ын таван эмэгтэй төлөөлөгчийн нэг аж.

2021 оны байдлаар Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын гишүүдийн ердөө 17 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь дэлхийн дундаж болох 24 хувиас нилээд доогуур байна. Мөн оны байдлаар орон нутгийн ИТХ-ын түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл ердөө 27.1 хувьтай байна. Эмэгтэйчүүд эрчүүдтэй эн тэнцүү боловсролтой, чадвартай хэдий ч Монгол Улсад бүх шатны шийдвэр гаргах түвшинд одоог хүртэл тэгш оролцоотой, төлөөлөлтэй байж чадахгүй байсаар байна.

Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийн талаарх Монголчуудын уламжлалт болон хэвшмэл ойлголтууд нь Монгол Улсад одоог хүртэл шийдвэр гаргах, манлайллын түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн нэг томоохон шалтгаан хэвээр байна. Үндэсний Статистикийн Хорооны 2019 оны судалгаагаар Монгол Улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.6 дахин илүү цагийг хөлс үнэлгээгүй гэрийн ажил хийхэд зарцуулдаг гэжээ.

Швейцарын Хөгжлийн Агентлагын санхүүжилттэйгээр НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, УИХ-ын Тамгын газрын хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээтэй хамтран зохион байгуулсан эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтанд сурч авсан мэдлэг, мэдээлэл үнэ цэнтэй байсныг Дэлгэр дурьдан ер нь

“энэ төрлийн сургалт орон нутгийн ИТХ-ын эмэгтэй гишүүдэд ажил мэргэжлийн хүрээнд өсч чадавхжих, шийдвэр гаргах түвшинд хүрэхэд чухал ач холбогдолтой” гэдгийг онцолж байна.

Булган аймгийн Гурванбулаг сумын анхны эмэгтэй засаг дарга Б.Дэлгэр ©НҮБ-ын ХХ

НҮБ-аас Төрийн албаны Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд 3,086 эмэгтэй төрийн албан хаагчид төрийн захиргааны удирдах ба ахлах албан тушаалд горилох боломж олгож, чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсан. 2018 онд явуулсан Төрийн албаны жендэрийн эрх тэгш байдлын анх дугаар үндэсний суурь судалгаанаас гарсан зөвлөмжийн дагуу НҮБ-аас Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг цар тахлын хөл хорионы үед боловсруулж, хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилласан бөгөөд энэхүү хөтөлбөрийг Төрийн албаны зөвлөл 2021 онд

баталсан юм. Төрийн албаны эмэгтэй албан хаагчдад чиглэсэн энэ хөтөлбөр Монгол Улсын төрийн захиргааны хувьд анхны хөтөлбөр бөгөөд төрийн албанд удирдах ба өндөр албан тушаал хаших эмэгтэй албан хаагчдын дараагийн үеийг бэлтгэхэд гол зорилго нь оршдог. НҮБ-аас үзүүлсэн тодорхой дэмжлэг, Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн албаны удирдах ба өндөр албан тушаал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 2016 онд нэг оронтой тоонд буюу 8 хувь байсан нь 2022 онд хоёр оронтой тоонд буюу 21 хувьд хүрч өссөн байна.

ГАРЦ 3.3

Залуучуудын холбоо, байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний үр дүнтэй оролцоог нэмэгдүүлж, үзэл бодлоо эрх тэгш, чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих

НҮБ 2017 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг анхлан боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Үүний дараа Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл байгуулагдаж, 21 аймаг, 320 сум, 23 баг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт нийт 373 залуучуудын дэд зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл залуучуудын хувьд тулгарч буй гол асуудлаа хэлэлцэн, санал боловсруулж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад хүргэх гол хөшүүрэг болж байна. Эдгээр зөвлөл байгуулагдсаны үр дүнд төр засгаас залуучуудыг хөгжүүлэх, чадавхжуулахтай холбоотой амлалт үүрэг ч нэмэгдэж, 2018-2022 оны хооронд холбогдох үйл ажиллагаанд 2.3 тэрбум төгрөг зарцуулах шийдвэр гаргасан байна.

НҮБ, Засгийн газар хамтран үндэсний хэмжээнд 21 аймагт Залуучууд хөгжлийн 46 төвийг байгуулж, ажиллуулсан.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд эдгээр төвүүд 95,000 гаруй залуучуудад зөвлөх үйлчилгээ, ажил мэргэжлийн чиг баримжаатай болох үйлчилгээг хүргэсэн.

Төрийн болон төрийн бус төрөл бүрийн байгууллагыг эгнээдээ нэгтгэсэн Зохистой хөдөлмөрийн төлөөх Монголын залуучуудын сүлжээ НҮБ-ын дэмжлэгтэй байгуулагдсан. Энэ сүлжээ эрэгтэй, эмэгтэй залуучуудын ажиллах хөдөлмөрлөх эрхийг дэмждэг. Хөдөлмөрийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт батлагдсанаар тус сүлжээ Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчлэлийг өргөжүүлэх, албадан ба хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хувь хүний баримт бичгийг барьцаа болгохыг хориглох, ижил түвшний ажил гүйцэтгэж ижил түвшний цалин хөлс авдаг байх, бэлгийн мөлжлөг зэрэг ажлын байран дахь бүх хэлбэрийн хүчирхийлэл, мөлжлөгийг хориглох зэргээр зохистой хөдөлмөрлөх эрхээр хангах, хуулийн заалтуудыг хэрэгжүүлж, мөрдүүлэх дээр идэвхтэй ажиллах болсон.



Багдуалет НҮБ-ын Хүн амын сангаас Баян-Өлгий аймагт байгуулсан Залуучуудын хөгжлийн төвийн байнгын үйлчлүүлэгч байв. ©НҮБХАС

БАГДАУЛЕТЫН ТҮҮХ:

ЗАЛУУЧУУДЫГ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ ТӨВ

НҮБ-ын Хүн амын сангаас санаачилсан Залуучуудын хөгжлийн төв нь Монголын залуучуудад эерэг нөлөө үзүүлж байгаагийн нотолгоо болсон оюутан Д.Багдуалетыг танилцуулъя.

Тэрээр тус төвийн үйл ажиллагаатай танилцсаны дараа хичээлийн дараа чөлөөт цагаа тус төвд өнгөрүүлж, өөрийгөө хөгжүүлэх болжээ. Тэрээр Залуучуудын хөгжлийн төвийг сурч, хөгжих том боломж гэж үзсэн.

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн төвүүдийг одоо Засгийн газар ажиллуулж байна. Тус төвүүд нь залуучуудад тэсвэр тэвчээрийг төлөвшүүлэх, амьдрах ухаанд суралцах, манлайлах чадвар эзэмших үйлчилгээ үзүүлдэг. Мөн Залуучуудын хөгжлийн төвүүд нь залуучуудад гэр бүл төлөвлөлт, шийдвэр гаргах болон бусад чиглэлээр дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, амьдрах ухааны сургалтад хамрагдах аюулгүй орчноор хангадаг.

Багдуалет тус төвд манлайлах, харилцах, гадаад хэлний чадвараа хөгжүүлж, энэ нь түүний ирээдүйн сурлага, карьерт үнэ цэнтэй хувь нэмэр болсныг онцолж хэлэв. Тэрбээр, тус төвийг дэлхийн залуучуудтай өрсөлдөхөд шаардлагатай шинэ ур чадварт суралцахад маш их тус болсон гэж сайшаав.

Багдуалет тус төвд сурсан ур чадвар, мэдлэгийнхээ ачаар Их Британи Улсад суралцах тэтгэлэг хүртэж чаджээ. Байгуулагдсанаас нь хойш олон залуучууд улсын хэмжээнд Залуучуудын хөгжлийн төвүүдэд шаардлагатай үйлчилгээ дэмжлэгээ авч, суралцаж, өөрсдийнхөө ирээдүйд хувь нэмэр оруулжээ. Залуучуудын хөгжлийн төв нь Монголын залуучуудын хувийн болон мэргэжлийн өсөлтөд чухал ач холбогдолтой гэж үздэгээ Багдуалет онцоллоо.

2.3 “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-2030” ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ТҮНШЛЭЛИЙГ ДЭМЖИХ

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн хугацаанд НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, түншлэлийн хүрээгээ тэлэх замаар “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн зорилтуудыг хангахад хувь нэмэр оруулах хөрөнгийг хандивлагч байгууллагуудаас амжилттай татан төвлөрүүлсэн билээ.

Монгол дахь НҮБ нь Монгол Улсын Засгийн газар, олон улсын тусгай сангууд, олон улсын төрийн байгууллагууд, ИНБ-ууд (олон улсын болон үндэсний), хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагууд, сургалт судалгааны байгууллагууд зэрэг 160 гаруй байгууллагатай хамтын ажиллагаа, түншлэлээ өргөжүүлээд байна.

©ОУХБ



“КОВИД-19” ЦАР ТАХАЛТАЙ ХАМТЫН ХҮЧЭЭР ТЭМЦЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮНШЛЭЛ

НҮБ нь Засгийн газар болон хөгжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж “КОВИД-19” цар тахлын эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй авахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө татан төвлөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, ДЭМБ-ын техникийн тусламж, зөвлөмж “КОВИД-19” цар тахлын эсрэг вакцины бэлэн байдлын төлөвлөлт, зохицуулалтын механизмыг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн. НҮБ-ын Хүүхдийн сангаас Гавийн КОВАКС хөтөлбөртэй хамтран цар тахлын эсрэг авах хариу арга хэмжээг авч, вакцинжуулалтын санхүүжилтийг шуурхай татан төвлөрүүлж чадсан.

НҮБ-ын Хүн амын сан Оюу Толгой ХХК-тай түншийн холбоогоо өргөжүүлж, иж бүрэн тоноглогдсон полимеразийн гинжин урвал (PCR) бүхий 4 лаборатори байгуулах санхүүжилтийг авч, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад тэргүүн шугамд ажиллаж байгаа ажилтнуудыг хувь хүний хамгаалах хэрэгслээ хангах, полимеразийн гинжин урвал (PCR) технологи ашиглах лабораторийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), НҮБ-ХС, ДЭМБ-ын дэмжлэгтэй ОБЕГ-ын удирдлага дор олон нийтийг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлсэн “Гэрээ угаа, маскаа зүү” үндэсний аяныг зохион байгуулсан бөгөөд энэ аянд 1.7 сая гаруй хүн хамрагдсан байна. Түүнчлэн НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, ОУШХБ, НҮБ-ХС, НҮБХХ, НҮБ-ХАС, ХХААБ, ДЭМБ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Монголын улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагууд Монгол Улсын Засгийн газартай хамтран “КОВИД-19” халдвар авсан анхны тохиолдол болон халдвар авсан иргэдийг гутаан доромжлохын эсрэг зогсож, эмч цагдаа зэрэг тэргүүн шугамд ажиллаж буй албан хаагчдыг дэмжих зорилгоор “Дэмжье, талархъя” аяныг зохион байгуулсан.

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ БА ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол дахь НҮБ нь тогтвортой хөгжлийн асуудал нь хүн бүрийн асуудал гэдгийг ухуулан сурталчилж, ТХЗ-уудыг санхүүжилтийн хийдлийг арилгахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж ирсэн сайн туршлагатай билээ. НҮБХХ ноолуур болоод бусад салбаруудад төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгоход гол зохицуулагч, зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байна. НҮБХХ Тогтвортой ноолуурын платформоор дамжуулан төрийн байгууллагууд, хувийн хэвшил, ИНБ-ууд, малчдын нөхөрлөлүүдийг нэг дор цуглуулж, тус тусын ашиг сонирхол бүхий талуудыг зөвшилцөлд хүргэж, хамтын ажиллагааг сайжруулж чадсан юм. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас (АҮХБ) Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилттэй “Монгол Улсын экспортыг дэмжих” төсөлд техникийн туслалцаа үзүүлсэн ба НҮБ-ын АҮХБ-н төв болон Хятад дахь бүсийн оффисын дэмжлэгтэйгээр төслийн хэрэгжилт, хяналт, үнэлгээг хийсэн.

ЗУДЫН ЭРСДЭЛД ЭРТ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТҮНШЛЭЛ

НҮБ-аас 2022 онд зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэн, тусламжийн санхүүжилт босгоход чухал үүрэг гүйцэтгэв. Монгол Улсын Шадар сайд болон НҮБ-ын Суурин зохицуулагчаар ахлуулсан хүмүүнлэгийн баг олон талт хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж, зудын аюулд өртсөн иргэдэд 2.8 сая ам.долларын тусламжийг Онцгой, нөхөн сэргээх үйл ажиллагааны тусгай сан (SFERA), Улаан загалмай болон улаан хавирган сар нийгэмлэгийн олон улсын холбоо, Швейцарын хөгжлийн агентлаг, АНУ-ын ОУХА, Старт Сан, НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд, болоод олон улсын засгийн газруудаас татан төвлөрүүлж чадсан.

ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

ГЛОБАЛ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ


Монгол дахь НҮБ Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран 2022 онд “Олон улсын цахим шилжилтийн яриа хэлэлцээ”-г анх удаа зохион байгуулав. Энэхүү цахим хэлэлцээрт 5 тивийн 30 гаруй улсын 400 гаруй оролцогч оролцсон бөгөөд сэдэвчилсэн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 800 гаруй онлайн сонсогчид нэгдсэн байна. Тус хэлэлцээ Монгол төдийгүй үндэсний түвшинд цахим шилжилт хийж байгаа бусад улсуудын туршлага, сорилт, шийдлүүдийн талаар санал солилцох, ТХЗ-уудын хэрэгжилтийг хурдасгах платформ болоход чухал ач холбогдолтой байсан юм.



НҮБ-ын Суурин зохицуулагч Талан Мишра болон ЦХХ-ны сайд Н. Учрал нар Глобал дижитал яриа хэлэлцээ 2022 арга хэмжээний нээлтийн ажиллагаан дээр ©НҮБ-ын СЗГ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ӨДӨРЛӨГ

НҮБ-аас өнгөрсөн 2022 оны туршид тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-уудыг үндэсний тэргүүлэх чиглэл болгохыг тууштай дэмжсэн. “ТХЗ Нээлтэй Өдөрлөг”-ийг хотын төв талбайд зохион байгуулж, төр засгийн байгууллагууд, үндэсний тэргүүлэгч компаниуд, ИНБ-ууд бүхий 150 гаруй хамтрагч байгууллагуудыг нэгтгэн, тэдгээрийн ТХЗ-уудын төлөө хийж ирсэн ажил, үйл ажиллагааг танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд багаар бодоход 5,000 хүн оролцож, талбай дээр байрлуулсан байгууллагуудын мэдээллийн асраар зочилжээ. “ТХЗ Нээлтэй Өдөрлөг”-өөр дамжуулан Монгол Улс ТХЗ-уудад хүрэхэд хаана явж байгаа, зорилтуудыг хангахад цаашид хийгдэх алхмууд, хувь хүний болоод хамтарсан үйл ажиллагааг хэрхэн дэмжиж болохыг олон нийтэд танилцуулсан юм.



2.4 НҮБ-ын ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН: НҮБ-ын ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН УЯЛДАА, ҮР ДҮН, НӨЛӨӨ

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн сүүлийн жил болох 2022 онд НҮБ-ын Удирдлагын баг зорилтот үр дүнгүүдийг хангахын төлөө үр дүнтэй хамтран ажиллалаа. НҮБ-ын ХТХ-ний хөндлөнгийн үнэлгээний тайланд хэрэгжилтийн явцад тулгарч байсан хүндрэл, гарсан сургамжийг нэгтгэж өгсөн ба тус тайланд дурдсан гол зөвлөмжүүдийг НҮБ-ын 2023-аас 2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)” -г боловсруулахад тусгасан болно.

Өнгөрсөн жилийн хувьд НҮБ-ын шинэчлэлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи 4 дэх жил бөгөөд энэ жилийн хугацаанд НҮБ-ын Удирдлагын баг ТХХАХ-г эцэслэн боловсруулж, 2022 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газартай хамтран баталж гарын үсэг зурсан. НҮБ-ын Удирдлагын багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, ТХХАХ-г хэрэгжүүлэх хугацаанд суурин ба суурин бус байгууллагуудаас бүрдсэн нийт 23 төрөлжсөн байгууллага ирэх 5 жилд буюу 2023-2027 оны хооронд хамтран ажиллахаар боллоо.

НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ нь стратегийн тэргүүлэх 3 чиглэлтэй бөгөөд тэргүүлэх чиглэл бүрийн хувьд Үр дүнгийн бүлгүүд байгуулагдаж, сэдэвчилсэн болон дэмжих бүлгүүдийн тусламжтайгаар ТХХАХ-г амжилттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

НҮБ-ын Суурин зохицуулагчийн удирдлага дор НҮБ-ын Удирдлагын багаас 2023-2027 оны ТХХАХ-ний хэрэгжилтийг хангах Хамтын ажиллагааны төлөвлөгөөг (бүлэг үр дүнгээр) бэлтгэн гаргаад байна. НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраас Хамтын ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэхэд

аргачлал болон зохицуулалтын дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Энэхүү Хамтын ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэсэн нь НҮБ-ын системийн байгууллагууд хэрхэн үр дүнтэй хамтран ажиллаж, системийн хэмжээнд үр дүнд хэрхэн хяналт, үнэлгээ хийх талаарх сайн жишээ болсноос гадна ТХХАХ-г хэрэгжүүлэхэд системийн байгууллагуудын хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо, үр дүнтэй байдлыг хангахад нэн чухал юм.

НҮБ-ын Удирдлагын багийн 2023 оны тэргүүлэх зорилтуудтай уялдуулан НҮБ-ын сэдэвчилсэн бүлгүүд (Жендэр, Залуучууд, Хүний эрх гм) болон дэмжлэг үзүүлэх бүлгүүд (Хэвлэл мэдээллийн харилцаа хариуцсан, Үйл ажиллагаа хариуцсан гм) өөрсдийн Ажлын удирдамж болон стратегийг ТХХАХ-ийн хэрэгжилттэй уялдсан байдлаар шинэчиллээ.

НҮБ-ын Удирдлагын багаас 2022 оны Монгол Улсын төлөв байдлын шинжилгээ (ССА)-г хийж, улс орны хөгжлийн явц, тулгарч буй сорилтуудад дүн шинжилгээ хийсэн. Тус шинжилгээгээр “КОВИД-19” цар тахал болон Украин дахь дайны нөлөөгөөр инфляц нэмэгдэж, өрхийн амьжиргаа доошилсон хэдий ч эдийн засаг өнгөрсөн онд 4.8 хувиар өсч чадсаныг онцолсон юм. Өнгөрсөн онд төр засагт тодорхой шаардлага хүргэсэн иргэдийн тайван жагсаал хэд хэдэн удаа болж өнгөрсөн ба Засгийн газраас Шинэ сэргэлтийн болоод бусад бодлого, хууль тогтоомжийг санаачлан нэвтрүүлсэн ч улс орны хөгжил болон ТХЗ-уудыг хангахад ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх шаардлага чухлаар тавигдсан хэвээр байна.

НҮБ-ын Удирдлагын багаас 2022 онд НҮБ-ын системийн хамтын ажиллагааны хүрээнд дараах 2 хамтарсан хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлээ. Үүнд:

Монголд ТХЗ-ын санхүүжилтийн нэгдсэн арга барилыг нэвтрүүлэх: төр, хувийн хэвшил, хөгжлийн санхүүжилтийг оруулан ТХЗ-уудын санхүүжилтийн стратегийг боловсруулж, хэрэгжилтийг баталгаажуулахаар Засгийн газарт танилцуулсан. Санхүүжилтийн энэ стратегийг үндэсний тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үндсэн зорилготой Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийн хүрээнд боловсруулсан.

Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь: хамтарсан хөтөлбөрийг уламжлалт бус шинэлэг арга барилаар явуулсны үр дүнд малчид нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах нь нэмэгдэж, залуу малчдад чиглэсэн орлого бүрдүүлэх гарааны бизнесийн загваруудыг бий болгох төдийгүй малчдын үндэсний хөтөлбөрийг бий болгож, малчдын дунд нийгмийн даатгалын үр өгөөж, амьжиргаанд тустай ур чадвар хөгжүүлэх мэдлэг, мэдээллийг олгосон.

НҮБ-ын Удирдлагын багаас Засгийн газар, бусад оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллаж Монгол Улсын Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэлийг боловсруулж, Засгийн газраас 2023 оны 7 дугаар сард болох НҮБ-ын улс төрийн дээд хэмжээний чуулганд танилцуулахаар ажиллаж байна. Тус тайланг боловсруулахад НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас үзүүлэх техникийн туслалцаа болон ТХЗ-ын явцын дүн шинжилгээ, хүний эрхийн механизм зэргийг тайланд тусгах ажлыг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраас зохион байгуулан ажиллаж байна. Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэлд "Бүс нутгийн/орон нутгийн хөгжил, хот хөдөөгийн хоорондын хөгжлийн ялгаатай байдал"-ыг онцолж авч үзсэн ба тус асуудал нь Засгийн газраас анхаарлаа хандуулан, шийдэхээр ажиллаж байгаа тэргүүний ажил юм.

НҮБ-ын Удирдлагын баг улс төрийн яриа хэлэлцээ, өөрчлөлтийн төлөөх олон нийтэд чиглэсэн аянг хэвлэл мэдээллийн салбартай хамтран өрнүүлж, хөгжлийн асуудлыг сурталчлан, эерэг нөлөөллийг бий болгохоор зорин ажилладаг билээ. Бидний нөлөөллийн үйл ажиллагаа голчлон цахим шилжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээ, хувьсаж буй боловсрол, жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх, хүүхдийн эрх, хөдөлмөрлөх эрхийн хамгаалал, бүх нийтийн

болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эмх цэгцтэй шилжилт хөдөлгөөн, иргэд олон нийтийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг дээшлүүлэх, хүнсний системийн тогтвортой байдал зэрэг асуудал руу чиглэдэг бөгөөд нийгэмд эерэг өөрчлөлт бий болгох энэхүү нөлөөллийн ажил нь биднийг эрч хүчтэй, урам зоригтой ажиллах үндэс болдог. Зохион байгуулсан томоохон эерэг нөлөөллийн үйл ажиллагаанаас дурдвал ТХЗ-ын нээлттэй өдөрлөг, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян зэргийг нэрлэж болохоор байна.

Монгол дахь НҮБ-ын Мэдээлэл, харилцааны баг нийгмийн хамгааллын тогтолцоогоор дамжуулан малчдын эрсдэлийг даван туулах, аливаа цочрол, байгалийн гамшигт хариу арга хэмжээ авах боломжийг дэмжсэн НҮБ-ын хөтөлбөрийг үйл ажиллагааг сурталчлах зорилго бүхий хэвлэл мэдээллийн ажилтнуудтай хамтарсан анхны танилцах аяллыг зохион байгуулав. Тус аяллаар хэвлэл мэдээллийн 8 байгууллага, сэтгүүлчдийг урин оролцуулж, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төсөл хөтөлбөрийг газар дээр нь танилцуулж, тэдгээрийн эерэг нөлөө, үр дүнг онцолсон 20 мэдээ, мэдээллийг 10 гаруй мэдээллийн суваг, нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн юм.

НҮБ-ын Үйл ажиллагааны баг "Бизнесийн үйл ажиллагааны стратеги"-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тус стратегийн хүрээнд нэгдсэн үйл ажиллагааны тогтолцоонд шилжиж, нэгдсэн байдлаар үйлчилгээ үзүүлж, урт хугацааны гэрээ хийснээр илүү үр ашигтай ажиллах боломж нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, НҮБ-ын байрны засвар, тохижилт, харуул хамгаалалт, хэвлэл, мэдээлэл, технологийн үйлчилгээ, томилотт болоод авто машины түрээс (2019, 2021 оноос хойш үргэлжилж байгаа) зэрэг нийтлэг үйлчилгээ төрөлжсөн байгууллагууд хамтран үзүүлж, зардлын хувьд хэмнэлт гаргаж, үр ашигтай ажиллаж байна. Удирдлагын багаас "Бизнесийн үйл ажиллагааны стратеги"-д тусгагдсан нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийн төлөвлөгөөг тогтмол хянан ажиллаж байна.

НҮБ-н байр, төрөлжсөн байгууллагуудын үндсэн бөгөөд төсөл, хөтөлбөрүүд дээр ажиллаж байгаа ажилчдын талаарх мэдээллийг 2022 оны байдлаар "НҮБ-ны байрны нийтлэг төлөвлөгөө"-нд тусган, шинэчилж тус мэдээллийг НҮБ-ын мэдээллийн нэгдсэн платформд (UN-info) оруулсан.



2.5 ҮНЭЛГЭЭ, ХТХ-г ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ОЛЖ АВСАН СУРГАМЖ

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг НҮБ-ын ХТХ-ний Хамтарсан Удирдах хорооны захиалгаар 2021 оны 8 дугаар сараас 2022 оны 2 дугаар сарын хооронд хийж, гүйцэтгэсэн билээ. Тус үнэлгээний тайлангаас гарсан гол зөвлөмжүүдийг ирэх 5 жил хэрэгжүүлэх ТХХАХ-нд үр дүнтэй тусгаж, хамтын ажиллагааны хүрээг амжилттай хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүллээ. Дараах хүснэгтэд зөвлөмжүүдийн дагуу авч хэрэгжүүлсэн гол арга, хэмжээг нэгтгэн харуулав.

ХҮСНЭГТ 1: НҮБ-ын ХТХ-ний Үнэлгээний тайланд өгсөн гол зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ

Гол зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ	Гол зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ
<p>НҮБ-ын Удирдлагын баг, Засгийн газар дараагийн хэрэгжүүлэх НҮБ-ын ТХХАХ-г ТХЗ-уудаар нийтлэг нэг алсын хараа, эрхэм зорилготой байхаар боловсруулж, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-г боловсруулахад "Өөрчлөлтийн онол"-ыг ашигласан ба гарах үр дүнгүүд нь үр дүнгийн зорилтуудыг хангахад хүрэлцэхүйц байх, үр дүнгийн зорилтуудын түвшний үзүүлэлтүүдэд НҮБ-аас оруулсан бүх хувь нэмэр тусгагдсан байхаар авч үзсэн. НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-ний "Ажлын хамтарсан төлөвлөгөө"-г НҮБ-ын хөгжлийн төв оффисоос өгсөн зааврын дагуу боловсруулж, нэгдсэн байдлаар бэлтгэсэн нь үр дүнтэй байдлыг нэмэгдүүлсэн. Үзүүлэлтүүдийг хяналт, үнэлгээг хийх боломжтой байдлаар тодорхойлсон, ТХХАХ-ний үр дүнгийн үзүүлэлтүүдийг НҮБ-ийн системийн байгууллагуудын хяналт, үнэлгээ хариуцсан ажилтнуудтай олон удаагийн уулзалт хийсний үндсэн дээр тодорхойлсон. 	<p>НҮБ-ын Удирдлагын баг ТХХАХ-н хэрэгжилтийг жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо, чадавхыг нэмэгдүүлэхэд илүү чиглүүлэх шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> Үр дүнгийн зорилт 4: хүн-төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх нь жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад голлон чиглэсэн, энд тусгай үр дүн орсон. Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах нь НҮБ-ын Удирдлагын багийн 2023 оны тэргүүлэх зорилтуудын нэг бөгөөд тус асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна.
<p>Монгол Улсын Засгийн газар дараагийн хэрэгжих НҮБ-ын ТХХАХ-нд өөрийн хариуцах үүрэг, стратегийн менежментээ илүү бэхжүүлэх шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-ний стратегийн тэргүүлэх зорилтуудыг Засгийн газартай хамтран мөн бусад талуудыг оролцуулан тодорхойлж, тэдгээрийн үндэсний тэргүүлэх зорилтуудтай нийцүүлж өгсөн. Засгийн газар-НҮБ-ын хамтарсан Удирдах хороог байгуулж, ирэх 5 жилийн НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэв. Ажлын удирдамжийн дагуу хамтарсан Удирдах хороо хамгийн багадаа дор хаяж жилд 2 удаа хуралдаж, үр дүн, төлөвлөгөөгөө хэлэлцэнэ. 	<p>НҮБ-ын Удирдлагын баг, Засгийн газар дараагийн ТХХАХ-нд санхүүжилтийн нэгдсэн хүрээ бий болгох талаар авч үзэх, ТХЗ-2030 хөтөлбөрийг санхүүжүүлэх хэрэгслийг бий болгох шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> Ажлын хамтарсан төлөвлөгөөг үндэслэн нэг болон таван жилийн санхүүжилтийн хүрээг тодорхойлсон. Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн ерөнхий зураг, санхүүжилтийн шинэлэг боломжуудын дүн шинжилгээнд үндэслэн нөөц татан төвлөрүүлэх хамтын стратегийн санал боловсруулсан.
<p>НҮБ-ын системийн байгуулла-гууд ТХХАХ-г үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Үр дүнгийн бүлгүүд болон сэдэвчилсэн бүлгүүдийн хамтын ажиллагааг сайжруулж, эдгээр бүлгүүдийн Суурин зохицуулагч болоод Удирдлагын багт дэмжлэг үзүүлэн ажиллах шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> НҮБ-ын Үр дүнгийн бүлгүүдийг НҮБ-ын ТХХАХ-ний стратегийн тэргүүлэх зорилт бүрээр байгуулсан. Үр дүнгийн зорилтуудыг эдгээр бүлгүүд хамтын ажиллагааны хүрээнд биелүүлэхээр ажиллаж байна. Дэмжих бүлгүүд (мэдээлэл харилцаа, хяналт үнэлгээ, нөөцийн татан төвлөрүүлэлт) болон сэдэвчилсэн бүлгүүд (жендэр, хүний эрх)-ууд тухайн зорилтот үр дүнгүүдийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллана. Бүлэг бүрийн Ажлын удирдамжийг боловсруулж, шинэчлэв. Системийн байгууллагууд үр дүнгийн бүлгүүдийг ээлжлэн удирдахаар шийдвэрлэсэн ба энэ нь хамтын ажиллагааг нэмэгдүүлэхээр байгаа юм. 	<p>НҮБ-ын Удирдлагын баг ТХХАХ-г хэнийг ч орхихгүй байх зарчим, Суурин зохицуулагчийн удирдлага дор хүний эрхэнд суурилсан арга барилыг нэвтрүүлэхэд гол чиглүүлэх хэрэгсэл болгох шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> ТХХАХ-ний стратегийн бүх тэргүүлэх чиглэл болон үр дүнгийн зорилтуудад чиглүүлэх зарчмууд болох хүний эрх, жендэр, хэнийг ч ардаа орхихгүй байх гэсэн зарчмууд тусгагдсан.

2.6 САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 2: Санхүүжилт: үр дүнгийн зорилт, байгууллагаар, (2017-2022), (сая ам доллар)

НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн зорилт	Байгууллага	Нийт байгаа нөөц	Нийт шаардлагатай нөөц	Нийт зарцуулалт
ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1: Байгалийн нөөцийн хүртээмжтэй өсөлт, тогтвортой менежментийг дэмжих	ХХААБ	11.2	14.4	14.1
	ОУАЭА	2.6	2.5	2.4
	ОУХБ	1.9	1.9	1.8
	ОУШХБ	6.1	4.9	3.7
	НҮБХХ	33.3	36.4	24.3
	НҮБ-БОХ	7.2	6.5	5.6
	НҮБ-АНДБНЭЗНК	0.4	0.4	0.4
	НҮБ-БШУСБ	0.9	0.9	0.7
	НҮБ-ХАБИТАТ	4.3	4.3	4.3
	НҮБ-ХС	7.9	7.9	7.5
	НҮБ-АҮХБ	22.5	22.3	14.4
	НҮБ-ДХХ	0.3	0.3	0.3
	ДЭМБ	18.7	18.7	26.5
	НҮБ-ХАС	-	0.0	0.1
Үр дүнгийн зорилт 1 дүн		117.3	121.4	106.1
ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2: Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш нийгмийн үйлчилгээг дэлгэрүүлэх	ХХААБ	4.8	9.0	5.8
	ОУАЭА	1.6	1.6	1.5
	ОУХБ	1.0	1.0	1.2
	ОУШХБ	1.4	1.5	1.0
	НҮБ-БШУСБ	1.5	1.5	1.6
	НҮБ-ХАС	10.2	10.7	10.3
	НҮБ-ХС	45.3	44.8	42.9
	ДЭМӨ	13.5	13.8	12.0
НҮБ-ХДХВ/ДОХ	0.0	0.0	0.0	
Үр дүнгийн зорилт 2 дүн		79.4	83.9	76.2
ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3: Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх	ОУХБ	1.5	1.5	1.1
	ОУШХБ	1.7	1.7	1.7
	НҮБХХ	14.2	13.9	11.4
	НҮБ-БШУСБ	0.2	0.2	0.4
	НҮБ-ХАС	13.1	13.1	11.6
	НҮБ-ХАБИТАТ	0.3	0.3	0.3
НҮБ-ХС	4.2	3.7	3.9	
ДЭМБ	0.1	0.0	0.1	
Үр дүнгийн зорилт 3 дүн		35.2	34.5	30.5
Нийт		231.9	239.8	212.8

Эх сурвалж: UN-info

ХҮСНЭГТ 3: Нийт зарцуулалт, үр дүнгийн зорилтоор, жилээр, сая ам доллар, (2017-2022)

Он	Үр дүнгийн зорилт 1	Үр дүнгийн зорилт 2	Үр дүнгийн зорилт 3	Нийт
2017	12.5	6.0	4.3	22.8
2018	11.7	6.3	4.4	22.3
2019	11.8	8.1	4.8	24.7
2020	24.6	11.3	5.6	41.6
2021	24.4	29.2	5.2	58.7
2022	21.1	15.3	6.3	42.7
Нийт	106.1	76.2	30.5	212.8

Эх сурвалж: UN-info

ХҮСНЭГТ 4: Нийт татан төвлөрүүлсэн нөөц, санхүүжилтийн эх үүсвэрээр, сая ам доллар, (2017-2022)

Санхүүжилтийн эх үүсвэр	Татан төвлөрүүлсэн нийт нөөц	Эзлэх %
Глобал тематик сан	72.7	30%
Хоёр талт Засгийн газрын гэрээ	71.3	30%
НҮБ-ийн системийн байгууллагын сан	51.0	21%
Олон улсын ТББ	18.2	8%
Монгол Улсын Засгийн газар	13.9	6%
Олон улсын санхүүгийн байгууллага	7.5	3%
Хувийн хэвшил	4.3	2%
Бусад	0.9	0%
Нийт	239.8	100%

Эх сурвалж: UN-info

ХҮСНЭГТ 5: Нийт зарцуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын бүлгээр, сая ам доллар (2017-2022)

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын бүлэг	Нийт зарцуулалт	Эзлэх %
Монгол Улсын Засгийн газар	168.6	79.2%
Сургалт, судалгааны байгууллага	13.6	6.4%
Үндэсний ТББ	9.8	4.6%
Олон улсын ТББ	8.2	3.9%
Олон улсын санхүүгийн байгууллага	6.9	3.2%
НҮБ-ын системийн байгууллага	3.2	1.5%
Олон улс, гадаад улс орны засгийн газар	2.5	1.2%
Нийт	212.8	100%

Эх сурвалж: UN-info

3 БҮЛЭГ

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГААС 2023 ОНД ТӨВЛӨРЧ АЖИЛЛАХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс Засгийн газартай хамтран 2023-2027 онд хэрэгжүүлэх ТХХАХ-г хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн 2023 онд дараах асуудалд гол анхаарлаа хандуулна. Үүнд:

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг эрчимжүүлэх
- Хүртээмжтэй боловсрол
- Эмзэг бүлгийн хүмүүст нийгмийн хамгааллын үйлчилгээг тэгш хүртэх боломж олгох
- Ус, ариун цэвэр, эрүүл ахуй
- Бага насны хүүхэд болон өсвөр үеийнхний хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэх
- Жендэрт суурласан хүчирхийллээс хамгаалах, хариу арга хэмжээний чанартай үйлчилгээ авах боломжийг сайжруулах

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2

- Эрсдэлийг даван туулах чадвартай, тогтвортой хөдөлмөр эрхлэлт
- Эдийн засгийн шилжилт/төрөлжилтийг (цахим шилжилт, дэд бүтэц, цэвэр эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ) зэргээр дамжуулан хийх
- Тогтвортой санхүүжилт

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 4

- Салбар бүрийн эмэгтэйчүүдийн манлайлал
- Цахим шилжилт
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW), хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC)
- Эрэгтэйчүүд ба хэвшмэл ойлголт, эрэгтэйчүүдийн эрүүл мэнд



ХАВСРАЛТ:

ТАЙЛБАР

- Ахицтай** Бодит гүйцэтгэл суурь түвшнээс дээгүүр, гэхдээ зорилтод түвшиндээ хүрээгүй
- Хангагдсан** Бодит гүйцэтгэл тухайн зорилтод түвшиндээ хүрсэн, түүнээс дээш байгаа.
- Ухарсан** Бодит гүйцэтгэл суурь түвшнээс доогуур байгаа.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1:

#	Үзүүлэлт	Төлөв	Суурь үзүүлэлт	Зорилт	Бодит гүйцэтгэл 2022
1	Үндэсний эрчим хүчний тогтолцоонд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлэх	Ахицтай	7% (2015)	20% (2021)	18% (2021)
2	Ойн газар, сая га (эсвэл нийт талбайд эзлэх ойн талбайн %)	Хангагдсан	Ойн бүрхэвч 11 сая га буюу газрын гадаргын 8% (2015)	13.2 сая га, газрын гадаргын 8.5% (2020)	14.1 сая га, газрын гадаргын 9.1% (2020)
3	Нийт нутаг дэвсгэртэй харьцах ТХГН	Хангагдсан	17.4% (2015)	18% (2021)	20%
4	ДНБ-д эзлэх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувь	Ахицтай	5% (2014)	-	7%
5	Гамшгийн нөлөө – гамшгаас үүдэлтэй эдийн засгийн хохирол	Ухарсан	Байгалийн аюулт үзэгдлээс учирсан эдийн засгийн хохирол 21,961.5 сая төгрөг (2013)	19,765.35 сая төгрөг	108,200.12 сая төгрөг (2018)
6	Ядуурлын шугмаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь	Ухарсан	Үндэсний дундаж 21.6%; хот 18.8%; хөдөө 26%; хүүхэд 28.9% (2014), ажиллах муу 20.29% (2013)	Үндэсний дундаж 18% (2021)	Үндэсний – 27.8% (2021)
7	Ажилгүйдлийн түвшин	Ухарсан	үндэсний 7.5%	6% (2020)	Үндэсний – 7.8 (2021)

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:

#	Үзүүлэлт	Төлөв	Суурь үзүүлэлт	Зорилт	Бодит гүйцэтгэл 2022
1	Сайжруулсан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх %	Хангагдсан	64% (2015)	80% (2021)	87.60%
2	Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг хүн амын эзлэх %	Хангагдсан	60% (2013)	70% (2021)	70%
3	Хүүхдээ төрүүлэхээс өмнө хамгийн багадаа 6 удаа үзлэгт орсон эмэгтэйчүүдийн эзлэх %	Хангагдсан	83.8% (2014)	90%-иас дээш (2021)	91.60%
4	Залуучууд (15-24 насны)-ын дундах тэмбүү өвчний тохиолдлын хувь, 10,000 хүн тутамд	Ахицтай	10,000 хүн тутамд 60.4% (2014 суурь)	10,000 хүн тутамд 30.0% (2021)	46.5
5	Өсвөр насны хүүхэд (15-19 насны)-ийн төрөлтийн хувь, 1000 хүн тутамд	Хангагдсан	1000-д 40.4 (2014)	1000 хүн тутамд 36% (2021)	28
6	НҮБ-ын ХТХ-ийн хэрэгжилтийн хугацаанд гарсан эрүүл мэндийн шинэ ба/эсвэл шинэчлэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө, тоо	Хангагдсан	0 шинэ ба /шинэчлэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө (2016)	5 шинэ ба /шинэчлэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө (2017-2021)	10
7	Орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх стратегиа баталсан, хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо	Хангагдсан	1 аймаг, 1 дүүрэг (2015)	7 аймаг, 3 дүүрэг	30
8	Нэн ядуу бүлэг дэх хүүхдүүдийн бага ба дунд боловсролд хамрагдсан хувь (цэвэр)	Ухарсан	96.2% (2013), 85.4% (2013)	100% (2021), 95% (2021)	93%
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ЕБС-д бүртгэгдсэн байдал, %	Хангагдсан	44.4% (2010)	70% (2021)	71.60%
10	Нэн ядуу өрхийн эрүүл мэнд, суралцах, сэтгэлзүйн хяналтад байдаг 5 хүртэлх насны хүүхдийн хувь,%	Хангагдсан	77% (2013)	79% (2021)	86%
11	Нэн ядуу өрхийн бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж байгаа 36-39 сартай хүүхдүүдийн хувь,%	Ухарсан	35% (2013)	45% (2021)	32%
12	4 болон 8 дугаар ангийн хүүхдийн тоо, шинжлэх ухааны хичээлийн сурлагын үзүүлэлт, %	Хангагдсан	39.6% (4-р анги, 2015), 25.8% (8-р анги, 2015)	50% (4-р анги, 2021), 45% (8-р анги, 2021)	56% (4-р анги), 62% (8-р анги)
13	Нийгмийн даатгалын тогтолцоонд хувь нэмэр оруулдаг эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх %	Хангагдсан	84.4% (2014)	89% (2021)	91%

14	Нийгмийн хамгааллын зардал, ДНБ-ний хувиар, %	Хангагдсан	3.4% (2014)	4.4% (2021)	11.80%
15	Хоол тэжээлийн дутагдалтай 5 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх %	Хангагдсан	10.8% (2013)	9% (2021)	6.10%
16	Илүүдэл жинтэй хүүхдүүд (13-17 насны)-ийн эзлэх %	Ахицтай	11.5% (2013)	9% (2021)	10

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3:

#	Үзүүлэлт	Төлөв	Суурь үзүүлэлт	Зорилт	Бодит гүйцэтгэл 2022
1	Хүн бүрийн эрхийг хамгаалан, дээдлэх, наад захын эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ХЭТБ-ын илтгэл болон НҮБ-ын олон улсын гэрээ, конвенцуудын /ЭАБХУОУК, ЭЗСНОУП болон бусад/-ийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал	Хангагдсан	ХЭТБЭХ: 150/164 ЭАБХУК хүлээн авсан: 55 зөвлөмж	ХЭТБЭХ: багадаа 85% хүлээн авч хэрэгжүүлсэн зөвлөмж, ЭАБХУК: багадаа 85% хэрэгжүүлсэн зөвлөмж	Бүрэн хангасан: ХЭТБЭХ: 89% хүлээн авсан зөвлөмжийн хэрэгжилт. Үүнээс: бүрэн (56/150 зөвлөмж ба 37%), хэсэгчлэн (77/150 зөвлөмж ба 51%) 2 онцлох зөвлөмжийн хамт. ЭАБХУК: 90% зөвлөмж (47/55) хэрэгжсэн.
2	Бүх төрлийн алагчлалын эсрэг (ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, БЧБХ) хууль тогтоомжийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлэх.	Хангагдсан	Гэр бүлийн хүчир-хийлэл (ГБХ)-тэй тэмцэх тухай хуу-лийн шинэчлэлийг УИХ хэлэлцэж байна. Мөн залуучуудын талаарх бодлогыг боловсруулж, хүүхэд хамгааллын шинэ хуулийг УИХ-аар хэлэлцэж байна.	ГБХ-тэй тэмцэх тухай шинэчилсэн хууль, Залуучуудын хөгжлийн бодлого, хүүхэд хамгааллын тухай хууль, ялгаварлан гадуурхалтын эсрэг заалтуудыг баталж, хэрэгжүүлж байна.	Бүрэн хангасан: ГБХ, Хүүхэд хамгааллын тухай шинэчлэгдсэн хууль 2016 онд баталсан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2017 онд батлагдсан.
3	УИХ, төв орон нутгийн засаг захиргаа, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь, (ТХЗ 5.5.1)	Ахицтай	УИХ- 14.5%. Орон нутгийн ИТХ 27.3%, Сайдууд 10.1% ТНБД- 26.6%. Засаг дарга -0%	УИХ-30%. Орон нутаг ИТХ 30%, Сайдууд- 40%, ТНБД - 40%, Засаг дарга- 30%	Хангалтгүй: УИХ - 17.1%, аймаг, нийслэл хотын ИТХ 15%, сум дүүргийн ИТХ 28.6%, сайдууд 10% хүрэхгүй, аймгийн дарга нар 4% (1/21) (2/ 21)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

АНДБНЭЗНК	Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг-нийгмийн комисс
АНУ-ОУХА	Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг
АХБ	Азийн хөгжлийн банк
ББТ	Бичил биетний тэсвэржилт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГЗМС	Газарзүй мэдээллийн систем
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗХТ	Залуучуудын хөгжлийн төв
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБ-АУХБ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
НҮБ-БШУСБ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБ-ДХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Дэлхийн хүнсний хөтөлбөр
НҮБ-СДА	Нэгдсэн Үндэстний байгууллагын Сайн дурын ажилтан
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ХАС	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮБ-ХС	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан
НҮБ-Хабитат	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын суурьшлын хөтөлбөр
НҮБ-ХТХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн тусламжийн хүрээ
НҮБ-ХДХВ/ДОХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын ХДХВ/ДОХ-ын талаарх нэгдсэн хөтөлбөр
НҮБ-ТХХАХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
НҮБ-УАӨСК	Нэгдсэн Үндэстний байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУАЗА	Олон улсын атомын энергийн агентлаг
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОУТС	Олон үзүүлэлт түүвэр судалгаа
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХҮХ	Тогтвортой хөгжлийн үндэсний хороо
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УЦУОШГ	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
ҮСНС	Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХТ	Хүүхэд хөгжлийн төв
ХХЯ	Хүлэмжийн хийн ялгаруулалт

